



ЧИНГИС ХААНЫ  
ӨВ, СОЁЛЫН  
ХҮРЭЭЛЭН

№ 1 / 2022 он

# ЧИНГИС ХААНЫ ӨВ, СОЁЛ

ТАНИН МЭДЭХҮЙН СЭТГҮҮЛ

## CHINGGIS KHAAN HERITAGE AND CULTURE

MAGAZINE

Суут богд Чингис хаан мэндэлсний 860 жилийн ойд зориулав.  
Dedicated to the 860th Birth Anniversary of Chinggis Khaan

Ерөнхий редактор: Н.Саруул доктор (Ph.D)

Editor in Chief: N.Saruul (Ph.D.)

Дугаарыг эрхэлсэн:  
Х.Мэндсайхан (Ph.D)  
Э.Соёлмаа

Executive editors:  
Kh.Mendsaikhan (Ph.D)  
E.Soyolmaa

Англи хэлэнд орчуулсан: Ч.Хатанбаатар

Translated in English: Ch.Khatanbaatar

Англи хэлний редактор: Glenda Lee

English translation editor: Glenda Lee

Дизайнер: Ц.Түмэнжаргал  
Ж.Алмагүл

Layout design: Ts.Tumenjargal  
J.Almagul

Чингис хааны өв, соёлын хүрээлэн, 2022 он

Copyright @2022 Institute of Chinggis Khaan  
Heritage and Culture

Энэхүү сэтгүүлийн эхийг Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр дахин хэвлэх, хайлтын системд байршуулах, цахим болон фото хуулбар хийх, бичлэг хийх зэрэг аливаа хэлбэрээр хувилж олшруулах, түгээхийг хориглоно.

All rights reserved. No parts of this magazine may be reproduced, stored in a retrieval system, or transmitted, in any form or by any means, electronic, mechanical, photocopying, recording or otherwise, without prior written permissions in accordance with the provisions of the Copyright Act and other related laws.

Publisher: Institute of Chinggis Khaan Heritage and Culture

Phone: +976 7000 0046, +976 7000 0064

Email: info@chinggisinstitute.gov.mn

Web: www.chinggisinstitute.gov.mn

## АГУУЛГА

1. Мэндчилгээ
2. Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн танилцуулга
3. Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн үйл ажиллагаа
4. Танин мэдэхүй
5. Зочны булан
6. Шинэ номын танилцуулга

## CONTENTS

1. Director's Greetings
2. About us
3. Institute of Chinggis Khaan Heritage and Culture
4. Did you know...
5. Interview Corner
6. New Publications

ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠰᠣᠶ᠋ᠣᠯᠢ ᠬᠡᠷᠡᠭᠡᠯᠢᠨ





## МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 142 дугаар тогтоолоор “Чингис хааны өв, соёлын хүрээлэн”-г байгуулсан нь нийт хүн төрөлхтний түүхэнд монголчуудын дундаас цолгорон тодорсон мянганы их хүмүүн, суут богд Чингис хааныхаа алдрыг дуурсгасан анхны төрийн байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэх, улмаар “Чингис хааны өв, соёлын судалгаа”-г албан ёсоор дэлхийн монгол судлалын доторх тэргүүлэх нэгэн салбар, чиглэл болгон эрчимтэй хөгжүүлэх түүхэн чухал шийдвэр байв.

Өнгөрсөн гурван жилийн хугацаанд эрдэм шинжилгээ судалгаа, соёл, урлагийн бүтээлч ажил, хэвлэл нийтлэл тэргүүтэн олон талт ажил үйлсийн зэрэгцээ бид “Чингис хаан музей” үүсгэн байгуулах ашиглалтын өмнөх захиргааны чиг үүргийг амжилттай гүйцэтгэсэндээ бахархалтай явдаг билээ.

Их хааныхаа өв, соёлыг судалж, сурталчлан таниулах чиглэлээр гадаад, дотоодын судалгааны олон нийт, ер сонирхсон хэн бүхэнтэй хамтран ажиллахдаа бид туйлын баяртай байх болно. Энэ учирт мөнх хөх тэнгэр, хөрст алтан дэлхий, хүмүүн шимийн шүтэн барилдлага ажил үйлст машинд зохилдохын үндсэн шалтгаан нөхцөл болсон эрхэм та бүхнээсээ бодитоор болон сэтгэлээрээ хэзээ ямагт биднийг тэтгэн тусалж явахын хүсэлтийг айлтгая.

Эдүгээ манай хамт олон танин мэдэхүйн анхны сэтгүүлээ эрхлэн хэвлүүлж уншигч олон та бүхнийхээ оюуны таалалд өргөн барьж байна.

Эрдэм номын шимээр сайн сайхан бүхэн дэлгэрэх болтугай!

Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч,  
доктор (Ph.D) Н. Саруул

## DIRECTOR'S GREETINGS

Founding of the Institute of Chinggis Khaan Heritage and Culture by Mongolian Government Resolution No, 142, dated on the 10th of April, 2019, was a historically significant decision being a matter of initiating the first government organisation in modern Mongolia, named after Chinggis Khaan, whose fame is renowned in the entire history of humanity as a man of the millennium. This, itself, is a sufficient base for pointing to our government's aim to develop 'Chinggis Khaan heritage and culture studies' as a leading branch of Mongolian studies.

We are very proud of our institute for it has successfully fulfilled its roles as a pre-administration of Chinggis Khaan Museum as well as in regular research, publications and cultural activities for the last three years.

We will be delighted to wholeheartedly cooperate with both foreign and domestic organisations or whosoever is interested in studying and promoting Chinggis Khaan's heritage and culture. For this reason, we most kindly request you to support us, either physically or mentally, by any means since you are the main causes and conditions for creating favourable interdependence between the Eternal Blue Heaven, Golden Earth and Humanity that would enable the actualization of our missions.

Our valued colleagues are now offering our institute's first public magazine for your wide-ranging intellectual interests.

May all prosperities be spread like sunlight due to the best essences of illuminating knowledge!

An acting director,  
Institute of Chinggis Khaan Heritage and Culture, Ph.D. SARUUL Nasanbuyan





# ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүн төрөлхтний түүхэнд Чингис хааны оруулсан түүхэн гавьяаг алдаршуулах, XIII зууны Монголын түүхийг дэлхий нийтэд түгээн сурталчлах, нүүдэлчдийн өв, соёлыг хамгаалахад чиглэсэн нэгдсэн бодлого, зохицуулалт төдийлөн хангалтгүй байгаа учир Чингис хаан судлалын ажлыг гадаад, дотоодын судалгаа олон нийтийн оюун санааны төвлөрлийг бий болгосон хэлбэрээр хийх, Чингис хааны төдийгүй XIII зууны Монголын түүхийн судалгааг эрчимжүүлэх, олон улсад өөрийн үзэлт онол, байр сууринаас сурталчлан таниулах зорилгоор “Чингис хаан” судлалын үндэсний бие даасан хүрээлэнг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 142 дугаар тогтоолоор “Чингис хааны өв, соёлын хүрээлэн” нэртэйгээр байгуулсан билээ. Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 156 дугаар тогтоолоор тус хүрээлэн Соёлын яамны харьяанд шилжиж, өдгөө “захиргаа”, “эрдэм шинжилгээ”, “хамтын ажиллагаа, сурталчилгаа” гэсэн гурван хэлтэстэй, 25 ажилтантайгаар ажиллаж байна. Хүрээлэнгийн зорилго нь:

- “Чингис хаан судлал”-ыг Монгол судлалын нэг салбар чиглэл болгон хөгжүүлэх суурь судалгаа хийх;
- Чингис хаантай холбоотой ёслол, хүндэтгэл, нэр нэршлийг нийгмийн харилцаанд хэрэглэх хэм хэмжээ тогтоох, эрх зүйн орчныг бүрдүүлэх суурь судалгаа хийх;
- “Мянганы суут хүн Их эзэн Чингис хаан” түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд холбогдох суурь судалгаа хийх;
- Чингис хааны өв, соёлын баримт мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэх, баяжуулах;
- Монгол болон дэлхийн түүхэнд Чингис хааны гүйцэтгэсэн үүргийг алдаршуулах;
- Монголын Эзэнт гүрний түүхийг олон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулахад чиглэсэн гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүрэгтэй.

# ABOUT US

Considering the needs for a strong and unified policy including legal regulations for promoting accurate merits of Chinggis Khaan as well as the status of 13th century Mongolians in the world history and protecting nomadic cultural heritage, the Institute of Chinggis Khaan Heritage and Culture, a government functioning institute, dedicated to Chinggis Khaan Studies, was established by Mongolian Government Resolution No,142, dated on 10th of April, 2019. That is to say, it is dedicated to organising Chinggis Khaan Studies by the way of concentrating on the intellectual quests of both foreign and domestic scholars, intensifying not only Chinggis Khaan Studies, but also 13th-century Mongolian history as a whole and therefore, promoting them in accordance with our own independent thoughts and viewpoints. The Institute was transferred under the administration of the Ministry of Culture by Mongolian Government Resolution, No, 156, dated on 21st of October, 2020. Since then, the institute has been running its research activities along with 25 members of staff, organised in three sectors such as ‘Administration’, ‘Research’ and ‘Cooperation and Promotion’. The main aim of the institute is:

- To develop Chinggis Khaan studies as a leading branch of Mongol studies;
- To conduct research works on legislating Chinggis Khaan related social activities such as ceremonies, veneration, use of the name and so on;
- To conduct research works for developing historical tourism on Chinggis Khaan as a Man of the Millennium;
- To promote Chinggis Khaan’s roles in Mongolian history in particular and world history in general;
- To establish an integrated documentation and information database about Chinggis Khaan heritage and culture;
- To cooperate with domestic and foreign organisations for studying and promoting the Great Mongol history period.

Чингис хааны өв соёлын хүрээлэн  
 Chinggis Khaan Institute of Studies and Culture



**ЧИНГИС ХААНЫ ӨВ, СОЁЛЫН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**INSTITUTE OF CHINGGIS KHAAN  
HERITAGE AND CULTURE**



## “ЧИНГИС ХААН СУДЛАЛ”-ЫГ МОНГОЛ СУДЛАЛЫН НЭГ САЛБАР ЧИГЛЭЛ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ СУУРЬ СУДАЛГАА

- Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнтэй хамтарсан археологийн судалгааг Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Ханзатын байц гэдэг газарт 2020 онд хийж, Монголын Эзэнт гүрний үеийн 11 булшийг малтан судалсны үр дүнд богтог малгай, хоромсого, эмээл, дөрөө, хүрэл толь зэрэг 90 гаруй олдвор илрүүлсэн.



- 2021 онд Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнтэй хамтарсан археологийн судалгааг Хэнтий аймгийн Дадал сумын нутагт хийж, үр дүнд төмөр хутга, хэт, вааран сав, бороотой зэв, хаймуур зэв, нумын ясман наалт, ховдны ясан чимэг, ховдны ясан тээг, алтаар үйлдсэн ээмэг, хүрлээр үйлдсэн хос ээмэг зэрэг сонирхолтой олдворуудыг олсон.
- 2021 онд Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль болон “Чингис хаан” музейтэй хамтран Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Оорцог уул гэдэг газарт Монголын Эзэнт гүрний үед холбогдох бүлэг булш оршуулгын дурсгалаас богтаг малгай, богтаг малгайн дөрвөн төрлийн чимэглэл, төмөр дөрөө, төмөр амгай зуузай, төмөр хайч, дөрвөн төрлийн хүрэл толь, сумны зэв, гоёл чимэглэлийн зүйлс, саадаг зэрэг олон төрлийн сонирхолтой олдворуудыг илрүүлсэн. Эдгээр олдвор “Чингис хаан” музейн сан хөмрөгт үндсэн үзмэрээр бүртгэгдсэн.



## RESEARCH WORKS: ‘CHINGGIS KHAAN STUDIES’ AS A SIGNIFICANT BRANCH OF MONGOLIAN STUDIES

- An archeological excavation was successfully carried out on the Great Mongol Period burial site, in Delgerkhaan Soum, Khenty Aimag, in cooperation with the Institute of Archeology, Mongolian Science Academy. As a result, over 90 findings such as a royal woman hat called ‘Boqtaq’, bow carrying case, saddle, stirrup, bronze mirror, etc., were found in 11 burials.



- In 2021, the Institute had presented its archeological work report on an excavation in Dadal Soum of Khenty Aimag, which was carried out in cooperation with the Institute of Archeology, Mongolian Science Academy, during the ‘Mongolian Archeology-2021’ scientific conference.
- In 2021, an Archeological excavation of Great Mongol period burials was undertaken in Tuvshinshiree Soum, Sukhbaatar Aimag, in cooperation with the Mongolian University of Science and Technology and Chinggis Khaan Museum. Those new findings, such as the ‘Boqtaq’ hat, four types of ‘Boqtaq’ hat ornaments, iron stirrups, iron bridle-bits, iron scissors, 4 types of bronze mirrors, arrow tips, ornaments and arrow cases, etc., are now registered as display items of Chinggis Khaan Museum.



Чингис хааны судлалын нэг салбар чиглэл болгон хөгжүүлэх суурь судалгаа

ᠮᠣᠩᠭᠣᠯᠠᠨ ᠬᠠᠭᠠᠳᠠᠨ ᠲᠦᠭᠦᠬᠡᠨ ᠭᠠᠪᠶ᠋ᠭᠠᠭ  
 ᠰᠤᠷᠲᠠᠯᠴᠢᠯᠠᠨ ᠲᠠᠨᠢᠭᠤᠯᠠᠬᠤ, ᠦᠨᠳᠦᠰᠢᠨᠢ ᠪᠠᠬᠠᠷᠬᠢᠯᠢᠭ  
 ᠪᠦᠢ ᠪᠣᠯᠭ᠋ᠢᠨ ᠵᠣᠷᠢᠯᠲᠠᠶᠢᠨ ᠬᠦᠷᠦᠭᠡᠨᠳᠦ



**Монголын хаадын түүхэн гавьяаг сурталчлан таниулах, үндэсний бахархлыг буй болгох зорилтын хүрээнд:**

“Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн түүхийн хичээлийн сургалтын хөтөлбөр, сурах бичигт Чингис хаан болон Монголын Эзэнт гүрний түүхийн агуулгын судалгаа”, “Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн түүх, иргэний ёс зүйн боловсролын хичээлийн сургалтын хөтөлбөрийн агуулгын судалгааны тайлан”-г тус тус хийж, холбогдох саналыг боловсруулан Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлсэн.

**Research works: Promoting Historical Merits of Mongolian Kings and Strengthening National Pride**

The Institute has conducted some research and analysis on Chinggis Khaan and the Great Mongol History period contents in history and literature subjects’ programs and texts books for 6th to 12th grades of secondary and higher schools. Likewise, the Institute has conducted some analysis on ethics and history subjects’ programs for secondary and high schools. Based on this research, the institute worked out and submitted some evaluations and suggestions to the Ministry of Education and Science.

**МЯНГАНЫ СУУТ ХҮН ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН, ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААРХ СУДАЛГАА**

Хэнтий аймгийн нутагт баригдаж буй түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын үзэл баримтлал, үзүүлэг дэглэлт, үйл ажиллагааны талаар санал боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг БСШУС-ын сайдын тушаалаар 2020 онд байгуулагдсан.

Хүрээлэнгийн судлаачид 6 цогцолборын үзэл баримтлал боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, 30 орчим удаа хуралдаж “Их хуралдай”, “Шихихутуг-Их засаг”, “Монголын нууц товчоон” түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын үзэл баримтлалын төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна.

**RESEARCH WORKS: ‘CHINGGIS KHAAN STUDIES’ AS A SIGNIFICANT BRANCH OF MONGOLIAN STUDIES**

A working group was established by an Order of Education, Culture, Science and Sports Minister in 2020 for preparing proposal drafts of conception, displays and events related to ongoing projects of constructing historical tourism complexes in Khenty Aimag.

Our Institute researcher participated in preparing draft conceptions for six complexes. From these, the Institute worked out conceptions of ‘Ikh Khurildai’ (Great Assembly), ‘Shikhi Khutug-Ikh Zasag’ (Great Ruling Law) and ‘Mongolian Secret History’ complexes and submitted them to the Minister of Nature, Environment and Tourism for authorisation.





Эл ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран “Хэнтий аймаг дахь түүхэн аялал жуулчлалын 6 цогцолборын үзэл баримтлал, үзүүлэг дэглэлт боловсруулах ажлын хэсгийн хэлэлцүүлэг”-ийг 2020 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулан БОАЖЯ, Соёлын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, үзэл баримтлал боловсруулах ажлын хэсгийн гишүүд, судлаач, төслийн нэгжийн ажилтнууд, барилгын гүйцэтгэгч компанийн төлөөлөл оролцож, санал солилцсон.

**“Монголын түүх, соёлын аялал жуулчлал: Өнөөгийн байдал, хөгжлийн боломж”** сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг ШУТИС-тай хамтран зохион байгуулж, Монголын түүх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, арга хэмжээ, Хэнтий аймгийг түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлэх боломжууд, Монголын Эзэнт гүрний өртөө зам аялал жуулчлалын нөөц болох нь, Хэрлэнгийн Хөдөө Арал: Түүх, соёлын аялал жуулчлалын нөөц боломж, XII-XIII зууны монголчуудын зарим идээ, ундааг аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжийн тухай, Түүх, соёлын агуулга бүхий гар урлалын бүтээгдэхүүнийг аялал жуулчлалд татан оруулах боломж, Их Монгол улсын шүүх засаглалд Шихихутугийн гүйцэтгэсэн үүрэг нь аялал жуулчлалд үзүүлэх нөлөө, Зүүн бүсийн хөгжил, соёлын аялал жуулчлалын нөөц зэрэг 20 гаруй илтгэл хэлэлцүүлэв.

“Хэрлэн голын дээд урсгалын түүхэн аялал жуулчлалын нөөцийн судалгаа” хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



In cooperation with the Ministry of Nature, Environment and Tourism, the Institute had organised a forum on ‘Conception, displays and events related to six historical tourism complexes in Khenty Aimag’ on the 18th of September 2020.

In this forum, experts from the Ministry of Nature, Environment and Tourism, the Ministry of Mining and Heavy Industry, members of the working group for preparing proposal drafts of conceptions, other researchers, project staff and some representatives of construction companies for the complexes, participated and exchanged their ideas and views.

In cooperation with the Mongolian University of Science and Technology, the institute had organised a scientific conference on ‘**Mongolian History and Cultural Tourism**’ and published its compilation of reports. Numbers of interesting scientific reports were included such as (1) ‘State Policies and Measures on Developing Mongolian History and Cultural Tourism’; (2) ‘On Development Opportunities for Developing Khenty Aimag as a Historical Tourism Region’; (3) ‘Road Stations of Great Mongolia as a Resource for Tourism’; (4) ‘Khuduu Aral of Kherlen River: Opportunities for Historical Tourism’; (5) ‘On Possibilities of Introducing 12th and 13th Centuries Mongolian Food and Drinks as Tourism Products’; (6) ‘Possibilities for Linking Hand-made Products as those are Related to History and Culture into Tourism’; (7) On Roles of Shikhi Khutag in Developing Great Mongol’s Court Ruling and Their Impacts on Tourism’; (8) ‘On Development of East Zone and Its Tourism Resources’, etc.

The Institute conducted a field work research titled, ‘Historical Tourism Resources in the Upper Stream Part of the Kherlen River’.



ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ ᠲᠡᠭᠦᠨ ᠰᠡᠭᠡᠨ ᠠᠶᠢᠯᠠᠯ ᠵᠤᠯᠤᠯᠠᠯ

100 жилийн өдөр  
 Чингис хааны  
 үйл ажиллагаа

## МОНГОЛ БОЛОН ДЭЛХИЙН ТҮҮХЭНД ЧИНГИС ХААНЫ ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРГИЙГ АЛДАРШУУЛАХ АЖИЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны тушаалаар 2020-2021 онд “Чингис хаан” музейн ашиглалтын өмнөх захиргааны чиг үүргийг тус хүрээлэн хариуцан ажиллаж дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:


- Чингис хаан музейн бүтээн байгуулалтыг эхлүүлэх ёслолын арга хэмжээг 2020 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсан.
- “Чингис хаан” музейн үзэл баримтлалыг Монгол Улсын Ерөнхий сайдаар батлуулсан.
- 3-8 дугаар давхрын үзүүлэг дэглэлтийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэгт хүрээлэнгийн судлаачид ажилласан.



## PROMOTION OF CHINGGIS KHAAN'S ROLES IN MONGOLIAN HISTORY IN PARTICULAR AND THE WORLD HISTORY IN GENERAL

The Institute had acted as a pre-administration of Chinggis Khaan Museum between 2020 and 2021 by an Order of Education, Culture, Science and Sports Minister. The Institute had successfully organised following works:

- The opening ceremony for laying the foundation of Chinggis Khaan Museum construction work was organised on the 2nd of April, 2020;
- A conception of the ‘Chinggis Khaan’ Museum was prepared and had it approved by the Mongolian Prime Minister;
- Institute researchers participated in preparing display planning for the museum halls from the 3rd to 8th floors;
- Decided upon a list of display items, copies of which should be obtained from foreign countries.



2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Шинжлэх Ухааны Академийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэн, Чингис хааны өв, соёлын хүрээлэн хамтран “Монголын нууц товчоон: Түүхэн газар нутгийн судалгаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, Монголын нууц товчоонд бичигдсэн түүхэн дурсгалт газруудын байршил, газар нутгийн нэрийн судалгааг эрчимжүүлэх судалгааны шинэ үр дүнг танилцуулах, цаашдын зорилтыг тодорхойлох зэрэг асуудлаар гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын 20 гаруй илтгэл хэлэлцүүлсэн.



On the 23rd of October, 2020, in cooperation with the Institute of History and Ethnography and the Institute of History and Archaeology, Mongolian Academy of Sciences, our institute had organised an international scientific conference themed, ‘The Secret History of the Mongols: Historical Site Studies’.


Approximately 20 scholars, both domestic and foreign, presented their scientific papers on precise locations of historical sites as are mentioned in the Secret History of the Mongols, intensifying researches regarding place names and presenting new research outcomes, determining future objectives and so on.



2020 оны 10 сарын 23-ны өдөр  
 “Монголын нууц товчоон: Түүхэн газар нутгийн судалгаа”  
 сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал

Монголын нууц товчоон зохиогдож дууссаны 780 жилийн ойд зориулан “Монголын нууц товчоон судлал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийг эрхлэн хэвлүүлсэн.

The Institute published a compilation of scientific reports titled, ‘The Secret History of the Mongols Studies’, from those submitted to a scientific conference dedicated to the 780th Anniversary of the completion of the Secret History of Mongolia.





ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠯ ᠠᠵᠢᠯᠢᠯᠠᠭᠠᠭ᠎ᠠ  
 ЧИНГИС ХААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ЧИНГИС ХААНЫ ӨВ, СОЁЛЫН БАРИМТ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ЦАХИМ САН

Чингис хаан болон Монголын эзэнт гүрний үед холбогдох баримтын бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сан (гадаад, дотоод хадгалагдаж буй эх сурвалж, судалгааны бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, биет болон биет бус өв, аудио, дүрс бичлэг, гэрэл зураг, хөшөө дурсгал гэх мэт) бүрдүүлэхээр ажиллаж байна. Эл ажлын хүрээнд Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй Чингис хааны тахилга сүлд, алтан ургийн угсааны засаг ноёд, Хан Хэнтий уулын тайлга тахилгатай холбоотой баримтыг хуулбарлах ажил хийгдэж байна.



## AN INTEGRATED DOCUMENTATION AND INFORMATION DATABASE ABOUT CHINGGIS KHAAN HERITAGE AND CULTURE

The institute is continuously collecting rare and interesting research sources and documents such as movable and immovable heritage, research reports of field works, audio and video tapes, paintings, photos, monumental statues, maps, etc., whatever is related to Chinggis Khaan and Great Mongol period history. Photocopying of the National Central Archive documents related to 'Offering Rituals to Chinggis Khaan's Insignia, Chinggisid Governors, and Making Offerings to Khan Khenty Mountain, etc., are in process for the time being.



## МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ТҮҮХИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ, СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХАД ЧИГЛЭСЭН ГАДААД, ДОТООДЫН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Соёлын яам, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас хэрэгжүүлсэн "Соёлын цаг" хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр тус хүрээлэнгийн үйл ажиллагааг олон нийтэд танилцууллаа. Энэ үеэр хүрээлэнгийн судлаачид Монголын Эзэнт гүрний түүхэнд холбогдох сонирхолтой сэдвүүдээр танилцуулга лекц уншсан нь олны анхаарлыг татсан юм.



## COOPERATING WORKS WITH DOMESTIC AND FOREIGN ORGANISATIONS FOR STUDYING AND PROMOTING THE GREAT MONGOL HISTORY PERIOD

The Institute introduced its activities and research works on the 9th of September, 2020 at the Sukhbaatar Square by participating in the 'Cultural Time' program organised by the Minister of Culture and Secretariat of Capital Governor. Our researchers delivered interesting lectures on the Great Mongolian Empire during this event.





“Монголын нууц товчооны түүхэн газар нутаг: Хэрлэнгийн хөдөө арал”, “Монголын нууц товчооны түүхэн газар нутаг: Ононы Дэлүүн болдог” сэдэвт богино хэмжээний баримтат кинонуудыг бэлтгэн гаргаж, МҮОНРТ, MN25 телевиз болон цахим сүлжээгээр түгээж, давхардсан тоогоор 14000 гаруй иргэдэд хүргэсэн.



The Institute had produced two short documentary films titled, ‘Historical Sites Related to the Secret History of the Mongols: Khuduu Aral of the Kherlen River’ and ‘Historical Sites Related to the Secret History of the Mongols: Delun-Boldog of the Onon River’ and broadcasted them through Mongolian National Broadcasting Television, MN25 TV Channel and other web-based platforms.



Чингис хааны өв, соёлын хүрээлэнгээс санаачлан Монгол Улсын Үндэсний Төв Архив, Монголын Үндэсний Музейтэй хамтран “Чингис хааны угсааны засаг ноёдын тамга” үзэсгэлэн, номын нээлтийг 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Үзэсгэлэнгийн үеэр 20 шахам засаг ноёдын тамгыг дэлгэн үзүүллээ.

“Чингис хааны угсааны засаг ноёдын тамга” бүтээлд Монгол Улсын Үндэсний Төв Архив, Монголын Үндэсний Музейд хадгалагдаж буй Манж Чин гүрний үеийн 60 шахам хошуудын тамганы зураг, дардсыг хэвлүүлж судалгааны эргэлтэд оруулав.

Opening ceremony of the research work publication and exhibition titled, “Seals of Chinggisid Governors” was organised on the 21st of Oct, 2021 at the initiation of the Institute of Chinggis Khaan Heritage and Culture in cooperation with the Mongolian National Central Archive and National Museum.

“Seals of Chinggisid Governors”, a research work, presents stimulating studies about the 60 Qing Dynasty period administration seals of Mongol Khoshuus /Banners/ which are preserved at the Mongolian National Archive and National Museum funds together with their photos of inscriptions.



“Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан сурагчдын соёлын тухай мэдлэгийг хөгжүүлэх зорилгоор “Бидний бахархал-Монголын нууц товчоон” хүүхдийн гар зургийн уралдааныг зарлан зохион байгуулав. Уралдаанд нийслэл, орон нутгийн сурагчдаас нийт 320 уран зураг ирүүлснээс 6 бүтээлийг шалгаруулан шагнасан төдийгүй эдгээр бүтээлээс сонгон хүүхдэд зориулсан хялбаршуулсан “Монголын нууц товчоон” бүтээлд хэвлэж олон нийтийн хүртээл болгохоор ажиллаж байна.


The Institute organised “The Secret History of the Mongols – Our Crown Ornament” painting art competition among children as a way of creative celebration of “Chinggis Khan’s Birthday” /National Pride Day/ in order to promote knowledge about our national history and culture. We received 320 paintings from around the country and nominated 6 child artists for a special honorarium. Some of these paintings are going to be published in a simplified version of ‘the Secret History of the Mongols’ for children, which is now in process.

Чингис хааны өв соёлын хүрээлэн

## “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ШАЛГАРСАН БҮТЭЭЛҮҮДЭЭС



"Ахлах анги" ангилал: Нэгдүгээр байр  
Зургийн нэр: ТЭМҮЖИН БООРЧИ ХОЁР АНД БОЛОЛЦСОН НЬ  
"Бадмаараг" ахлах сургуулийн 12в ангийн сурагч Э.Сүхбат



"Ахлах анги" ангилал: Хоёрдугаар байр.  
Зургийн нэр: НАЙМАН ШАРГА  
"Бадмаараг" сургуулийн 12в ангийн сурагч С.Ёндонсамбуу



# “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ШАЛГАРСАН БҮТЭЭЛҮҮДЭЭС

ᠠᠬᠤᠯᠠᠬᠤ ᠠᠩᠭᠢ



"Ахлах анги" ангилал: Гуравдугаар байр.  
Зургийн нэр: ЧИНГИС ХААН  
"Ирээдүй" догцолбор сургуулийн 12ж ангийн ангийн сурагч Л.Хөлгөнсүдар




"Ахлах анги" ангилал: Тусгай байр  
Зургийн нэр: ЧИНГИС ХААНЫ АМЬДРАЛ  
12-р сургуулийн 6в ангийн сурагч Д.Жаргал



ᠪᠢᠳᠨᠢᠢ ᠪᠠᠬᠠᠷᠬᠠᠯ ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠨᠠᠭᠤᠴ ᠲᠣᠪᠴᠣᠨ ᠬᠡᠭᠦᠳᠢᠶᠢᠨ ᠭᠠᠷ ᠵᠤᠷᠭᠢᠶᠢᠨ ᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨᠢ ᠰᠠᠯᠭᠠᠷᠰᠠᠨ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠦᠭᠦᠳᠡᠰ

## “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ШАЛГАРСАН БҮТЭЭЛҮҮДЭЭС



"Ахлах анги" ангилал: Тусгай байр  
Зургийн нэр: ИХ ХУРАЛДАЙ  
62-р сургуулийн 9в ангийн сурагч Э.Бямбарэгчаа



"Ахлах анги" ангилал:  
Зургийн нэр: ТЭМҮЖИН ГУРВАН МЭРГЭДИЙГ ДАРСАН НЬ  
"Бадмаараг" ахлах сургуулийн 11в ангийн сурагч Б.Анужин




# “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ШАЛГАРСАН БҮТЭЭЛҮҮДЭЭС

ᠪᠢᠳᠠᠨᠢ ᠪᠠᠬᠠᠷᠬᠠᠯ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠨᠠᠭᠤᠴ ᠲᠣᠪᠴᠣᠨ ᠬᠡᠭᠦᠳᠡᠢ ᠬᠠᠭᠠᠨ ᠰᠢᠷᠭᠢᠨ ᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨ ᠰᠢᠯᠭᠠᠷᠰᠠᠨ ᠪᠦᠲᠡᠭᠡᠯᠦᠳᠡᠭᠡᠰ



"Ахлах анги" ангилал:  
Зургийн нэр: ӨГӨДЭЙ ХААН  
"Бадмаараг" ахлах сургуулийн 12в ангийн сурагч Т.Соёл-Эрдэнэ




"Дунд анги" ангилал: Нэгдүгээр байр.  
Зургийн нэр: ТЭМҮЖИН ХААН ШИРЭЭНД СУУСАН НЬ  
24-р сургуулийн 7ж ангийн сурагч Б.Эгшиглэн



## “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ШАЛГАРСАН БҮТЭЭЛҮҮДЭЭС



"Дунд анги" ангилал: Хоёрдугаар байр.  
Зургийн нэр: ХАДААН  
1-р сургуулийн 7в ангийн сурагч Б.Оюундулам



"Дунд анги" ангилал: Гуравдугаар байр.  
17-р сургуулийн 6в ангийн сурагч Г.Билэгт

“Чингис хааны өв, соёл” I, II, III боть бүтээлийн нээлтийг 2021 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Энэ үеэр Монголын нууц товчоон цуглуулагч, доктор, дэд профессор Э.Пүрэвжавын 40 гаруй жил цуглуулсан гадаадын 30 гаруй хэлээр хэвлэгдсэн Монголын нууц товчоон номын үзэсгэлэнг зохион байгуулсан.

Opening ceremony of the first, second and third research work volumes of ‘Chinggis Khaan Heritage and Culture’ Serials was organised on the 9th of September, 2021.

On the same day, the Institute organised an exhibition on ‘The Secret History of the Mongols’ Publications’. ‘The Secret History of the Mongols’, which was translated and published in over 30 foreign languages, was displayed to the public community during this exhibition. These were Professor E. Purevjav’s private collections from the last 40 years.

2021 оны 9 сарын 09-ний өдөр  
 “Чингис хааны өв, соёл” I, II, III боть бүтээлийн нээлт



Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Английн Хааны Газарзүйн Нийгэмлэгтэй хамтран “Монгол орон ба Монголчууд”, Дани Улсын Үндэсний музейтэй хамтран “Дани дахь Монголчуудын өв, соёл”, ОХУ-ын Эрмитажийн музейтэй хамтран “Эрмитаж дахь эзэнт гүрний үеийн дурсгалууд” бүтээлийг тус тус эрхлэн хэвлүүлсэн.

In 2021, the Institute published ‘Mongolia and Mongols’, a photo album, in cooperation with the Royal Geographical Society UK, ‘Mongolian Cultural Heritage Items in Denmark Catalogue’ in cooperation with International Association of Mongolian Studies and Amalienborg Palace in Copenhagen of Denmark and the ‘Hermitage Museum Cultural Items of the Great Mongol Empire Catalogue’ in cooperation with the State Hermitage Museum of Russia.



МҮОНРТ-тэй хамтран “Мөнх тэнгэрийн ивээл дор” 60 минутын баримтат нэвтрүүлгийг бүтээж, олон нийтийн хүртээл болгож Их Эзэн Чингис хааны гавьяаг сурталчилсан.

‘Under the auspiciousness of the Munkh Tenger’, a documentary program 60 minutes in length, was produced and broadcast in cooperation with the Mongolian National Broadcasting Television.

**ЧИНГИС ХААНТАЙ ХОЛБООТОЙ ЁСЛОЛ, ХҮНДЭТГЭЛ, НЭР НЭРШЛИЙГ НИЙГМИЙН ХАРИЛЦААНД ХЭРЭГЛЭХ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ СУУРЬ СУДАЛГАА**

**RESEARCH WORKS ON LEGISLATING CHINGGIS KHAAN RELATED SOCIAL ACTIVITIES SUCH AS CEREMONIES, VENERATION, USE OF NAME., ETC.**

Хүрээлэнгийн судлаачид Чингис хаантай холбоотой ёслол, хүндэтгэл, нэр нэршлийг нийгмийн харилцаанд хэрэглэх хэм хэмжээ тогтоох, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар суурь судалгааг хийж байна.

The Institute researchers are conducting some studies on the social demands and necessities for legislating Chinggis Khaan related social activities such as ceremonies, veneration, use of the name., etc.





Prof. PIERGIORGIO VALENTE  
 President, CFE Tax Advisers  
 Europe, Professor, Link Campus  
 University in Rome.

He read this poem in Ulaanbaatar  
 when he was invited by CFE Tax  
 Advisers Mongolia in 2019.

“Chinggis khaan”

Mock not the defenceless cub.  
 It may turn into a ferocious tiger.  
 In Genghis' soul the conquering  
 exodus  
 broke through the Han wall  
 and, through it, rent the horizon,  
 beyond the physical confines of  
 conventional living spaces.  
 Genghis left his own world  
 behind,  
 in foreshadowing the exodus, and  
 found it once again within,  
 at the journey's achievement of  
 such exodus,  
 drawing a new world to himself.  
 The wind as companion, a horse  
 as a brother  
 and an anda, Jamuka, as his  
 childhood friend;  
 his teachers were the affront  
 against his own father Yesugei  
 and the shadows of forebears,  
 hostilely tempered by clime's  
 harshness.  
 The steppe – with its fleeting  
 smile of irises –  
 birthed legions of horses to ride  
 from yellowed vales in autumn,  
 on the same-scented grasslands  
 in spring  
 and unceasingly in summer,  
 where the horizon seemed to  
 always reveal a new beyond,  
 gradually different, and yet,  
 always the same.



**Европын Татварын  
 Мэргэшсэн Зөвлөхийн  
 Холбооны Ерөнхийлөгч,  
 Италийн Линк Кэмпус Их  
 сургуулийн профессор  
 PIERGIORGIO VALENTE  
 “Чингис хаан” шүлэг**

*(Монголд хэлэнд орчуулсан  
 Ч.Хатанбаатар.)*

Хариугүй нялх хэмээн  
 бамбарыг бүү элэг барь  
 Хүчирхэг догшин бар болон  
 хувирч мэднэ ээ тэр.

Олныг дагуулсан Чингисийн  
 сүр сүлд  
 Хан улсын хана хэрмийг давж  
 Оршин ахуйн тогтсон  
 хязгаарын чандад гарч  
 Хөхрөгч тэнгэрийн хаяа лугаа  
 сүлэлдэн одсон билээ.  
 Өөрийн орон ертөнцийг ардаа  
 орхисон ч тэрээр  
 Зөн билгийн их ертөнцдөө  
 түүнийг дахин олсон юм.  
 Үргэлжид ялгуусан их аян  
 дайны тоосноос  
 Үлэмжийн шинэ ертөнцийг  
 бүтээсэн юм, Чингис.  
 Аясын салхиар хань,  
 Аргамаг хүлгээр ах дүү хийж  
 Анд Жамухыг гагц багын  
 нөхрөө болгосон түүнд  
 Эцэг Есүхэйгээс урван  
 тэрслэгчид,  
 Элэнц өвгөдийн сүүдэр,  
 Эгнэгт хахир хатуу нутгийн цаг  
 агаар л  
 Эрхэм сайн багш болж байлаа.  
 Алтан намар хүлэг морьд  
 дэргэдэг нуга хөндий  
 Аяа бас, хавар, зуны алинд ч  
 ялгалгүй  
 Үнэр анхилуун зүлэгт дэвсгэе  
 Үзэсгэлэнт солонгын  
 инээмсэглэлтэй тал нутгийн  
 хаяа  
 Үргэлжид ялимгүй өөр мэт  
 боловч угтаа ялгаваргүй  
 Шинэ шинэ газрыг чандаас  
 чандад нээж өгөх мэт ээ.

“Chinggis khaan”

Non schernire il cucciolo indifeso.  
 Può divenire la tigre feroce

Nell'animo di Gengis l'esodo di  
 conquista  
 si fece breccia nel muro degli Han  
 e, attraverso di essa, squarciò  
 l'orizzonte,  
 oltre il confine fisico del consueto  
 spazio vitale.

Gengis rimosse il proprio mondo  
 da sé,  
 nella prefigurazione dell'esodo, e  
 lo ritrovò in sé,  
 al termine del cammino  
 dell'esodo,  
 traendo un nuovo mondo a sé.

Gengis rimosse il proprio mondo  
 da sé,  
 nella prefigurazione dell'esodo, e  
 lo ritrovò in sé,  
 al termine del cammino  
 dell'esodo,  
 traendo un nuovo mondo a sé.

Ebbe compagno il vento,  
 fratello il cavallo e un anda,  
 Jamuka;  
 gli furono padri l'affronto al padre  
 Jesugei  
 e le ombre degli avi, temprate  
 ostili dall'astioso clima.  
 La steppa – dal fugace sorriso  
 degli iris –  
 partorì così tanti cavalli  
 per cavalcare dalle valli ingiallite  
 in autunno,  
 sull'erba di un solo profumo in  
 primavera  
 e senza requie in estate,  
 che l'orizzonte sembrava scoprire  
 sempre un oltre,  
 via via diverso, ma pur sempre  
 eguale.

Potenti e spietate le immense  
 regioni mongole si fecero carne,  
 in uomini e cavalli fusi insieme:  
 in una macchina perfetta - uomo-  
 cavallo-arco -  
 dal mito riemerse reale  
 l'ippogrifo.  
 Dalle pungenti nebbie, le terre  
 nomadi  
 rigurgitarono indomiti cavalieri,  
 che si raccolsero in schiere,  
 e le schiere in Minghaan; e poi, a  
 migliaia, in Tumen,  
 al comando di Orlok con medaglie  
 dal rango forgiato nell'oro.

Чингис хааны  
 өв соёлын  
 хүрээлэн

Powerful and ruthless the vast Mongol regions became flesh, in an intermingling of men and horses: become a perfect – man-horse-bow – machine, did the Hippogriff materially resurge from the myth. From the pungent mists, nomadic lands spewed forth indomitable horsemen, assembled in regiments, and the regiments in Minghaans; and then, in thousands, in Tumens, at Orlok's command with rank medals forged in gold. The army swelled into a swarm mighty and orderly. A giant earthen wave rippled throughout the steppes with interminable rides, in the ardour of a people who knew no bounds. Genghis' dream propagated itself in rushes for miles and miles on end traversing an ocean of earth, to become the nightmare of such peoples who – in the Mongolian exodus – refused subjection. Genghis was this: a man of the exodus. From boundless prairies, he impetuously hurled himself towards any land that could be fathomed. Each cardinal point fell prey to his genius, to his austere severity, in merciless determination. His men chased after the skies to the south, beyond the wall of the Han Dynasty. They pursued daybreak to the east; and stormed at sundown towards the portals of Vienna.

Хүчирхэг догшин Монголын өргөн уудам нутагт Хүмүүн хийгээд хүлэг морьдын махан овоо босов. Хүн-морь-нум хэмээх төгс оньсон зэвсэг бүтсэн нь Үлгэр домгийн морин бөгст бүргэд дахин төрсөн мэт ээ. Алтан хуяг дуулгаа гялбалзуулсан өрлөг жанжны тушаалаар Аравт, зуут, мянгат, түмтээрээ жигдэрсэн Хэнд ч үл дийлдэх морьтон баатрууд Холын нүүдэлчдийн нутгийн гүнээс Хөхөмдөг манан будангийн дундаас Хөвөх үүлс мэт урсан гарч ирвэй. Үерийн ус мэт олон боловч Үнэн журамт хүчирхэг цэргийн түрлэг Зах хязгаар гээчийг үл мэдэх Зоригт дайчдын цог жавхлангаар Үелзэх шороон давалгаа мэт Өргөн талыг нөмрөн урсвай. Богд Чингисийн их суу билиг Бээр бээрийн чанад дахь газрыг эзлэхийн Далай мэт эрчлэн довтолгох заль хүчин болж Баатарлаг монголчуудын байлдан эзэрхэхийг Дагахыг үл хүсэгчдийн хар дарсан зүүд болвой. Эзэн богд Чингис бөгөөс Энэ их байлдан дагуулыг эрхшээгч байлаа. Хөвөө хязгааргүй талаас Хэмжиж болохуйц газар бүрийг чиглэн Харвасан сум мэт дүүлсэн дайчин байлаа. Зүг, зовхис бүхэн түүний суу зальд сөгдөв. Хатуу чанга зан буцалтгүй бат шийдвэрийнх нь өмнө бүгд бөхийв. Хүчирхэг олон цэрэг эрс нь Хан улсын хэрмийг давж Өмнийн тэнгэр зүгт довтолгов. Үүр хаяарах дорныг ч дайлав. Үдшийн наран жаргах Венн хотын Үүд хаалгыг ч хэмх дэлдэв. Өмнө, дорно хийгээд өрнийг бүрэн дайлж дагуулав. Эрхшээх эзэнгүй аюулт тэнгис Эгнэгт үхмэл хоосон лугаа гэрээт

L'esercito si fece marea, possente ed ordinato. Uno tsunami di terra increspò l'infinita steppa di interminabili cavalcate, nell'ardore di un popolo che non conobbe limite. Il sogno di Gengis riuscì a propagarsi in folate per migliaia di chilometri, attraversando un intero oceano di terra, per farsi incubo per i popoli che, nell'esodo mongolo, non si sottomiserò. Ecco: Gengis fu uomo dell'esodo. Da praterie senza confine si lanciò impetuoso su ogni possibile terra. Ogni punto cardinale fu preda del suo genio, della sua severità austera, in spietata determinazione. I suoi uomini rincorsero il cielo a sud, oltre la muraglia degli Han per arrestare l'altrui oltre, concepita per introdurre un bordo all'alone non-Han e per demarcare il dentro cinese dal nemico-fuori. A est incalzarono l'alba; e si lanciarono sul tramonto fino alle porte di Vienna. Il sud fu abbattuto, e così l'est e l'ovest. Solo il nord rimase intatto, ad agghiacciare col vento artico l'animo, muto nel silenzio di gelo in terre senza nome, rattrappite nell'intirizzito vuoto digradante su mari estremi senza padrone.

Per Gengis la yurta divenne il cielo, azzurro come il lupo; e Lupo, di terra famelico, si unì con la cerbiatta fulva, nutriti entrambi dal sangue dei popoli vinti in ogni punto cardinale. I Mongoli furono il corpo di Gengis; con loro e per loro dissuggellò la fenditura della storia verso il futuro, dispose l'ordito di un nuovo inizio,



Defeated was the south, as were  
the east and the west.  
The north alone remained  
unscathed,  
with the arctic wind congealing  
the soul,  
mute in the silence of chill in  
nameless lands,  
contracted in the numbed and  
waning emptiness  
on hazardous seas without lords.

For Genghis, the yurt became his  
sky,  
as blue-gray as the wolf,  
the ravenous land Wolf, united  
with the fawn-coloured Doe,  
nourished by the blood of peoples  
vanquished in every cardinal  
point.  
The Mongols grew into Genghis'  
own body;  
with them and for them did he  
unlock  
the seal of history's breakthrough  
towards the future,  
weaving the warp for a new  
beginning,  
which contributed to shape a  
renewed fabric  
to meld the people of the steppes.  
All in Mongolia now bears his  
name:  
an entire people lives in him and  
in him is revived.  
Genghis' dream gallops on,  
unvanquished,  
with the proud people of the  
steppes:  
the perpetual howling of the blue-  
gray wolf  
warns the moon:  
Mock not the defenceless cub.  
It may turn into a ferocious tiger.

The vilified orphan is now at  
peace,  
with the shadow of history's  
vastest empire nestled nigh

Дуудах нэргүй  
Дурсах хүнгүй  
Сүнсийг ч хөлдөөж мэдэх  
Салхи эсгичсэн умар зүг л  
хөндөгдөлгүй үлдвэй.  
Чонон саарал тэнгэр  
Чингисийн өргөө гэр нь болов  
Талын араатан ( Бөртэ) чоно  
Танхил согоо (Хоо марал) лугаа  
гэрлээд  
Зосон улаан цусаар тэтгэгдэж  
Зүг, зовхис бүхнийг эрхэнд  
хураав.  
Даяар олон монголчууд  
Далай их Чингисийн бие болж  
өсөв.  
Тэрбээр түүхийн аньс учиг  
тайлж  
Тал нутгийн олон түмнийхээ  
Саруул зам, гэрэлт ирээдүйг  
баталгаажуулсан  
Шинэ утсыг урлаж бөхлөн  
холбож өгсөн билээ.  
Өдгөө бүх монголчууд түүний  
нэрээр гоёж байна.  
Өргөн олноороо түүний суу  
залиар амьдран тэтгэгдэж  
байна.  
Чингисийн хүсэл зориг  
Чин зоригт талын хүмүүсийн  
хамтаар  
Хөхөмдөг саранд хандсан  
Хөх чонын мөнхийн улианд  
Чухамхүү ялагдашгүй хэвээрээ  
Чанх босоо довтолгож байна.

Хариугүй нялх хэмээн  
бамбарыг бүү элэг барь  
Хүчирхэг догшин бар болон  
хувирч мэднэ ээ тэр.

Хүн төрөлхтний түүхэн дэх  
Хамгийн том эзэнт гүрний  
сүүдэр  
Замхарч арилаагүй эрхэм  
чөлөөнд  
Зовлон туулсан өнчин хөвгүүн  
өдгөө тайван амгалан...

che – insieme ai fili della trama  
individuale –  
concorse a formare  
il rinnovato tessuto connettivo  
dei popoli delle steppe.

Tutto in Mongolia ora ha il suo  
nome:  
un popolo intero vive di lui e in lui  
(ri)vive.  
E il sogno di Gengis galoppa  
invitto  
col popolo altèro delle steppe;  
e, nell'imperituro ululato del lupo,  
azzurro ammonisce la luna:

Non schernire il cucciolo indifeso.  
Può divenire la tigre feroce

L'orfano vilipeso ora riposa in  
pace,  
l'ombra del più esteso impero  
della storia accoccolata accanto...






ПАНМОНГОЛИЗМ

Панмонголизм! Хоть имя дико,  
Но мне ласкает слух оно,  
Как бы предвещием великой  
Судьбины Божией полно.  
Когда в растленной Византии  
Остыл Божественный алтарь  
И отреклся от Мессии  
Иерей и князь, народ и царь, —  
Тогда он поднял от Востока  
Народ безвестный и чужой,  
И под орудьем тяжким рока  
Во прах склонился Рим второй.  
Судьбою павшей Византии  
Мы научиться не хотим,  
И все твердят льстецы России:  
Ты — третий Рим, ты — третий  
Рим.  
Пусть так! Орудий Божьей кары  
Запас еще не истощен,  
Готовит новые удары  
Рой пробудившихся племен.  
От вод малайских до Алтая  
Вожди с восточных островов  
У стен поникшего Китая  
Собрали тьмы своих полков.  
Как саранча, неисчислимы  
И ненасытны, как она,  
Нездешней силою хранимы,  
Идут на север племена.  
О Русь! забудь былую славу:  
Орел двуглавый сокрушен,  
И желтым детям на забаву  
Даны клочки твоих знамен.

ДАЯАР МОНГОЛ ҮЗЭЛ

Даяар Монгол Үзэл! Догшин,энэ  
нэршил  
Дээрх бурхад төөргийг нь  
бүрэн болгоож  
Дэнсэлж тогтоосон төлөг лүгээ  
Дэндүү аятайхан сонсогдож  
байна, чихэнд минь.  
Буурч доройтсон Византид  
Бурхан шүтээн өнгө алдахуйд  
Ариун Есүс Христээс ард, тайж  
санваартан  
Адилхан цугаараа тэрслэн  
урважихуй.  
Тэгэхүй дор дорно зүгээс  
Тэр, энэ нь үл мэдэгдэх харь  
этгээд өндийв.  
Үйлийн үрээр хүнд зэвсэг дор  
нь  
Үнс нурам болов, хоёр дахь Ром.  
Сөнөсөн Византийн гашуун  
сургамжаас  
Суралцахыг бид хүсэцгээхгүй  
юм даа.  
Оросын зуйрганчууд бүгдээрээ  
Одоо Чи-гурав дахь Ром, гурав  
дахь Ром гэгцгээж байна.  
Болтугай, болтугай. гэвч  
Бурхны ташуур-гэсгээл  
Бас ч нөөцөө барчихаагүй  
байна.  
Бүүрлэж сэргэсэн угсаатны  
сүрэг  
Болох шинэ дайралтдаа  
бэлтгэж байна.  
Нэлгэр Малайн уснаас Алтай  
хүртэл  
Наран мандах арлын  
удирдагчид  
Үжирч доройтсон хятад цагаан  
хэрмийн хажууд  
Үй олон хороо болгон, цэргээ  
засаж байна.  
Хавийн хүчинд эс дийлдэн  
Хамж цөлмөөд дуусгах  
царцааны  
Харанхуй нүүдэл шиг тэдгээр  
сүрэг хойд зүгийг чиглээд  
айсуй харагдана.  
Хуучин алдраа Орос, март:  
Хоёр толгойт бүргэд хэмхэрсэн,  
Хүү татуулсан тугны чинь  
өөдсийг  
Хөх толботой жаалууд тасчин  
тоглож байна.



PAN-MONGOLISM

By Vladimir Solovyov  
Pan-Mongolism! This cruel name,  
Resonates so pleasant in my ear,  
As if its destiny was thoroughly  
examined,  
In divinations of God.  
When main altar was deteriorated,  
In collapsing Byzantines,  
King and subjects, princes and  
ordained ones,  
All of them, equally, betrayed  
Holy Jesus.  
Meanwhile, God blessed unknown  
foreign nation,  
Raised up from the oriental realm.  
Second Rome was crashed into  
ashes  
Under their heavy weapons.  
We do not wish to learn from,  
Fatal destiny of collapsed  
Byzantines.  
All servile flatterers of Russia are  
repeating,  
'You are- third Rome, you are-  
third Rome'.  
May it be! But God's punishing  
weapon,  
Still not exhausted its resources,  
An awakening ethnic group is,  
Preparing for their new attacks.  
All oriental realm leaders,  
From Malayan waters to Altai  
Mountain,



Смирится в трепете и страхе,  
Кто мог завет любви забыть...  
И третий Рим лежит во прахе,  
А уж четвертому не быть.  
1 октября 1894  
Источник

Хайрын гэрээсээ хэн мартаж  
чадах нь  
Хүлцэл, айдастайгаа нөхөц  
дөө...  
Гурав дахь Ром ч нурман дунд  
хэвтэнэ.  
Дөрөв дэх Ром гэж бүр ч  
бүтэхгүй ээ.

.....

**Владимир Сергеевич Соловьёв  
(1853-1900)**

Хаант Оросын үеийн  
философич, яруу найрагч,  
нийтлэгч, утга зохиолын  
шүүмжлэгч.

Тухайн үеийнхээ Оросын  
улс төрд асар их нөлөө үзүүлсэн  
“Нармай Монгол” хэмээх энэхүү  
шүлгийн монгол орчуулгыг  
Я.Долгоржав, англи орчуулгыг  
Ч.Хатанбаатар нар үйлдэв.

Assembling their black armed  
forces,  
On long ranging Chinese great  
wall.  
Undefeatable force of ethnic  
group,  
As immeasurable as grasshoppers,  
And as sateless as they are,  
Marching towards the north.  
Oh Russia! Forget about your  
fame;  
Two-headed eagle is crushed and,  
Yellow children are playing with  
Torn off pieces of your flag.  
Who so ever can forget about love  
agreement,  
Face your tolerance and terror ...  
Third Rome is already lying down  
on dusts,  
And so, the fourth Rome.  
1st of October, 1894

.....

‘Pan-Mongolism’, a poem had  
greatly influenced on Tsarist  
Russian politics, is translated in  
Mongolian by Ya. Dolgorjav and in  
English by Ch.Khatanbaatar

Чингис хааны өв соёлын хүрээлэн

<sup>2</sup> Шүлгийн эх дээр “шар хүүхдүүд” гэж байгаа ч “хөх толбот хүүхдүүд” хэмээн буулгав. Энэ үеийн “Шарын аюул” гэдэг нэр томъёог янз янзаар ойлгож байсан ч энэ шүлгийг бичигч болон Орос оронд маш тодорхой ганц агуулгаар ойлгож байсан нь олон баримтаар тогтоогддог юм.(Я. Д)

<sup>3</sup> This poem, which was composed by Vladimir Soloyov in 1894, had greatly influenced on Russian politics at that particular time. Source: Библиотека Мошков.

<sup>4</sup> Yellow children’: this can indicate all Asians. Though, it refers to only Mongolians from the side of Russians at that period as one go through various documents. Thus, Mongolian translator of this poem changed this part as ‘Children with blue marks’ in his Mongolian version.

## СҮЛДЭНЭ ХӨХ ОВООНЫ ЦАГААН СҮЛД

Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Х.Мэндсайхан, докторант Ш.Мөнхбаатар.

Манжийн түрэмгийллээс хамгаалах зорилгоор Хархорумаас Их цагаан сүлд, Хар сүлдний дагуул тугуудыг зүүн, баруун өмнөд хязгаар нутгуудад байрлуулсан түүхтэй. Үүний нэг нь Халхын Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу буюу одоогийн Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт орших Сүлдэнэ хөх овоонд тахиж байсан цагаан сүлд юм. Үүнийг тахиж байсан тугчийн удмын хүмүүсийн үр сад Хөвсгөл суманд аж төрсөөр байна. Анх Хөвсгөл, Архангай аймгийн зааг дээр байсан харуул 50 орчим өрх айлыг цагаан сүлдийг тахиж, хамгаалахаар Хутаг уулын орчимд авч ирэн байршуулсан байна. Тэндээс “Тугчийнхан” гэдэг овог үүссэн төдийгүй тэднийг бас “Тосгоныхон” гэж нэрлэдэг байна. Ийнхүү 1640-1940 он хүртэл Тугчин отог цагаан сүлдийг (туг) хамгаалах, тахиж (тугнах) зан үйлээ үе дамжуулан тасралтгүй гүйцэтгэж иржээ.

Сүүлчийн тугч нь одоогийн Дорноговь аймгийн Хөвсгөл сумын VI багийн иргэн Пүрэвийн Дорж гэдэг хүн байжээ. 1937 онд улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршгаар олон сүм, хийдийг сүйтгэх үеэр цагаан сүлд өртөж, Улаанбадрах сумын хуучин төвийн хог дээр сүлдний хадаг яндар, цацаг манжлага тэргүүтнийг шатаан хаяжээ. Харин тугчийн отгийн нэгэн хүн сүлдний оройн гурван үзүүрт дог, ишний дунд хэсэгт ухаж тусгай жаазанд хийн хадгаар ороож байрлуулсан чүн чулуун бурхан, алтаар шармалдсан гуулин сэлэм барьж баруун өвдгөө нугалан суусан хамгаалагч баатар зэргийг олж хадгалсныг хожим нь сэргээж сүлдийг бүрэн болгож, улмаар аймгийн Музейн сургалт-судалгааны төвд хүлээлгэн өгсөн байна.

Цагаан сүлдийг тугнах үеэр зоог шүүс бэлтгэн морь уралдуулж, бөх барилдуулдаг байсныг тугчийн удмын хүн Н.Гүрцоо гуай ярьсныг эрдэмтэн судлаачид бүтээлдээ дурдсан байна. 1940 оны эхээр маршал Х.Чойбалсан Сүлдэнэ хөх овоонд ирж Цагаан сүлдэнд хүндэтгэл үзүүлсэн мэдээ байдаг.

Эдүгээ Монгол төрийн цагаан сүлдийг



## A WHITE BANNER OF THE SULDENE BLUE HILL

By Kh. Mendsaikhan and Sh. Munkhbaatar, the Institute of Chinggis Khaan Heritage and Culture

White and black banners, which were composed of the Nine White Sulde and Four Black Sulde were moved from Kharkhorin and placed in the east, west and south regions of Mongolia in order to protect the country from Manchu invasions. One of them was a white banner at the Suldene Khukh Ovoo of the Gobi Mergen Wang Khoshuu, Khalkha Tusheet Khan Aimag, which present location is in Khuvsgul county of Dornogobi province.

Descendants of Tugch family are still living these days in Khuvsgul county. It is said that about 50 families from an area in between present-day Khuvsgul and Arkhangai provinces were moved to a place around Khutag Mountain in order to carry out responsibilities relating to the protection of the White banner and performing its worship rituals. This was how a family called ‘Tugchiinkhan’ (it means those who are responsible for ‘Tug’ or banner) originated in this region. They are also named ‘Tosgoniikhon’. Thus, they flawlessly carried out their duties of protecting and worshipping the white banner from 1640 up to 1940.

The last official curator of the white banner was Mr DORJ Purev, who was from the present 4th Bag, Khuvsgul county of Dornogobi province. A nightmare like political repression in the 1930s, responsible for the destruction of hundreds of monasteries, did not spare the white banner either. White horse tail hairs, silk scarves, etc., components of the white banner were burnt and left on a garbage dump of the former central settlement of Ulaanbadrakh county. Fortunately, someone from the Tugch family had found the main parts of the white banner such as a trident top, a pole with a red stone deity and a brass embossed protector image, etc., and these were the basis for reviving the banner.

Forerunning scholars mentioned in their works that an extensive food and drink offering together with a horse racing and wrestling festival were organised during the worship of the white banner as Mr N. Gurtsoo from the Tugch family recalled. This indicates that the present-day Mongolian veneration of the Nine White Banners, respectfully bringing them to the centre of the Naadam festival for one day, is in accordance with exact tradition and is the highest form of worship.





жил бүр улсын баяр наадмаар цэнгүүлж буй нь уламжлалт ёсоо сэргээсэн хамгийн дээд хүндэтгэлийн хэлбэр юм.

Ашигласан эх сурвалж:

1. Н.Ишжамц Хутаг уулын хошуу УБ., 1998 он
2. С.Дулам Говь мэргэн вангийн хошуунд тахигдаж байсан “Хангал ихт цагаан тугийн” тахилга. Дорноговь судлал-III. УБ., 2012

## САРЛАГ ТОЛГОЙН (МОРИН ТОЛГОЙН) XIII-XIV ЗУУНЫ ҮЕИЙН СУУРИН

Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Гантогтох.

Архангай аймгийн Өгийнуур сумын төвөөс урд зүгт шулуунаар 6 километр тус сумын Дойт багийн нутаг Орхон голын баруун хөвөө, түүний нэгэн салааны баруун хажууд орших жижиг толгойг нутгийнхан Сарлаг толгой хэмээн нэрлэнэ. Сарлаг толгойн баруун урд хормойгоос Орхоны хөндийн дөрөвдөгч галавын маш зузаан хурдас дороос Сарлагийн рашаан ундарч гардаг ажээ. Харин Сарлаг толгойн зүүн хормойгоос эхлэн эртний барилгын ор буюу эртний сууцууд баруунаас зүүн тийш сунасан байрлалтайгаар 300 орчим метр урт нэгэн сувгийн ар, өвөр талаар цуварсан байдалтай оршиж байна. Уг сууцуудын баруун болон хойд талд залгаад эрт цагт бүхэлдээ Орхон голын салааг түшиглэсэн тариалангийн газар байсныг илтгэх ор мөр тодорхой мэдэгдэх ажээ. Уг сууринаас баруун өмнө зүгт 2 км-т Дойтын цагаан нуур орших бөгөөд энэ нуурын ойр орчимд эрт цагт байшин барилга бүхий суурин оршин байгаад үер усны аюулт өртөн сүйдсэн хэмээн нутгийн ардууд домоглон ярьдгийг Монголын ууган археологич Х.Пэрлээ 1950-аад оны үед тус нутаг орчмоор судалгааны ажлаар явах зуураа тэмдэглэн авсан байдаг. Үүнийг одоо ч Дойтын цагаан нуурын орчмоор нутаглах иргэд үе уламжлан ярилцаар ирсэн нь сонирхолтой. Бид түүхэн сурвалж болон домгийн мөрөөр сэжүүр хайн зайнаас тандан судлах ажлын явцад тус сууриныг илрүүлэн олсон юм.

Уг газраас паалантай цагаан, цэнхэр, бор, хар зэрэг олон өнгө, төрлийн шаазан эдлэлийн хагархай мөн паалангүй хар саарал, бор өнгийн вааран савны хэсгүүд олддог бөгөөд суурин газар байсныг илтгэх халгай, дэрс ургасан олон тооны шороон овор байгаа нь сонирхол татах бөгөөд тус газраас олдож буй шаазан эдлэлийн хагархайнууд Монголын эртний нийслэл Хархорум хотыг малтан судлах явцад олдсон зарим төрлийн шаазан эдлэлтэй ижилсэж байгаа нь тус хоттой нэг цаг үед холбогдох болохыг гэрчилнэ.

It is said that Marshal Kh. Choibalsan, himself, once paid a visit to Suldene Blue Hill in 1940 to pay his respects.

Today, this white banner is preserved and displayed at the Dornogobi province museum and education centre.

N.Ishjamts, 'Khutag Uul Khoshuu', UB., 1998  
S.Dulam, 'Offering Ritual of the White Banner', which was worshiped in Gobi Mergen Wang Khoshuu. Studies on Dornogobi-III

## ON AN ANCIENT SETTLEMENT IN THE SARLAG HILL

By G.Gantogtokh, a researcher of the Institute of Chinggis Khaan Heritage and Culture

A Small Hill called Sarlag Hill (Yak Hill) is located on the west bank of the Orkhon River in the territory of 'Doit' Bag ('Bag' is the smallest administration unit in Mongolian countryside regions), 6 kilometres due south of the 'Ugii Nuur' Soum of Arkhangai Aimag. There is a nectar stream that flows from the west foot of Sarlag Hill. It comes out through a thick mineral stratum that was generated during the Phanerozoic Eon under the Orkhon Valley. Starting from the foot of the eastern side of the hill, there are a number of ancient habitations' ruins lining the back and front sides of a groove that is extended about 300 meters from west to east. There are obvious traces of ancient crop fields based on the river branch to the north of the settlement. There is a lake called 'Doit Tsagaan', located 2 kilometres from the settlement to the south-west. A Mongolian pioneer archeologist Kh. Perlee had kept a note in the 1950s regarding local accounts of ruins of an ancient settlement, consisting of several constructions around this lake which had since disappeared due to floods.

It is interesting that the local community continues to talk about this ancient settlement even today. That is why we did some field studies and discovered this ancient settlement.

There is some evidence of the settlement such as numbers of mounds full of broom grasses and nettles growing; moreover, a considerably large quantity of porcelain pieces of various types and colours have been found. For example, there are many pieces of enamelled white, blue, brown and black porcelain pots as well as pieces with black grey and brown colours without enamel. According to our comparisons of these with those of similar findings from the ancient Mongolian capital, Karakorum, there are exact matchings. This itself can be regarded as enough evidence to say that this settlement existed in the same period as that of Karakorum.

Чингис хааны өв соёлын хүрээлэн

Харин Сарлаг толгойн оройд 8x8 хэмжээтэй дөрвөлжин байгууламж байсан ор мөр мэдэгдэх ба зүүн урд 200 метр зайд дөрвөлжин хэлбэртэй нэгэн жижиг хэрэм байрладаг, бүтэц зохион байгуулалт нь он цагийн уртад мэдэгдэх төдий болжээ. Хэрэм урдаас хойш 116 метр, хойд хананы урт баруунаас зүүн тийш 92 метр урт байх бөгөөд хэрмийн баруун талын ханатай залгаж барьсан нэгэн тасалгаа мэдэгдэж байна. Хэрмийн урд хэсэгт үүдэвч бүхий барилгын ор мэдэгдэх бөгөөд дундаж хэмжээ нь 28x23 метр ажээ. Хэрмийн хоймор хэсэгт 14x15 метр дөрвөлжин хэмжээтэй барилгын ор мэдэгдэж байлаа. Тус хэрмэн дотроос барилгын хар саарал өнгийн нөмрөг болон тосгуур ваар, барилгын тоосго газрын өнгөн хөрснөөс цухуйж гарсан байдалтай олон тоогоор мэдэгдэж байгаа нь ихээхэн сонирхол татаж байгаа юм. Мөн хэрмийн зүүн хойно хөшөө хэлбэртэй боржин чулуу газраас цухуйсан байдалтай байсан ба түүний хойно дөрвөлжин хэлбэрийн барилгын бас нэг боржин чулуун суурь байдаг.

Сарлаг толгойн сууринаас олддог хагархай хэсгүүдийг шавар болон шаазан эдлэл гэсэн үндсэн хоёр төрөлд ангилан үзэж болохоор байна. Лавтай мэдэгдэж байгаагаар Сүн улсын үеийн Жүн яо, Лун чен үү яо зэрэг шаазангийн хэлтэрхий олдож байна. Энэ төрлийн буюу Сүн, Юань улсын үед холбогдох шаазан эдлэлүүд өмнө нь Дойтын балгас, Шаазант хот, Шаазант, Мазар зэрэг газраас түүврээр олдож байжээ.

Археологич Д.Болдхуягийн судалснаар “Хархорум хотын туурийг үе үед археологийн талаар малтан шинжлэх явцад урьд энд зарим төрлийн шаазан эдлэлийг үйлдвэрлэж байсныг нотлох хангалттай эш баримт нэгэнт бүрдсэн бөгөөд тэрхүү хэрэглэгдэхүүнийг шинжин үзвэл ард түмний өргөн хэрэгцээнд зориулж олноор нь шатааж байсан Лун чен үү яо төдийгүй, мөн хэдийгээр язгууртан ноёдын хэрэгцээнд зориулж шатаах боловч тоо хэмжээгээр арвин их олддог, үйлдвэрлэлийн гологдол шинжтэй илрэх нь цөөнгүй Жүн яо шаазанг тус хотод үйлдвэрлэж байсан боловч уу хэмээн бид үзэж байна” хэмээсэн нь нэн сонирхолтой бөгөөд Сарлаг толгойгоос олдсон зарим төрлийн шаазан эдлэлийн хэлтэрхий дээр хулсан савхаар чанар шалгасан ул мөр бүхий нүхнүүд байгаа нь уг сууринд үйлдвэрлэж байсныг гэрчлэх баримт юм. Яг үүнтэй адил хулсны нүх бүхий шаазан эдлэл Хархорум хотын малтлага судалгааны явцад олдсоныг Германы судлаач Анна Хёсснер судлан өгүүлэл бичсэн байдаг.

Тус суурины улбааг түүхэн сурвалжийн мэдээтэй хамаатуулан үзвэл 1247 онд монгол нутгаар аялан явсан хятад аялагч Чжан Дэ Хуэй Бургатай болон Орхон гол, Хорины хөндийд газар тариалан, гар урлалын сууринууд оршин байсныг нүдээр үзсэн байдаг. Тэрээр Хархорум хотыг чиглэн аялан явах замдаа Өгий нуур, түүний баруун талд орших одоогийн нэрээр Чилэн балгасыг нүдээр үзэж цааш Орхон голыг өгсөн аялсан тухайгаа ийнхүү тэмдэглэсэн байдаг.

There is a trace of an 8 x 8-meter square construction on top of the Sarlag Hill. There is another trace of small fortification construction, which is located 200 meters away from the previous one to the southeast. Its exact structure and set-up are difficult to know due to the long passage of time since the works were done. The length of the fort from the south to the north is 116 meters and its width is 92 meters as per our measurement of the existing north wall trace. A trace of a room connected with the western wall of the fort can be seen. In the southern part of the fort, a trace of construction with an antechamber of approximately 28 x 23 meters is visible. There is one more four-sided construction trace of 14 x 15 meters in size at the uppermost part of the fort. Moreover, there are a number of black-grey roofing ceramics and bricks scattered elsewhere on this site as partly revealed on the surface. On the northeast side of the fort, a piece of granite that might be a statue is partly unearthed. Another piece of granite for the foundation of the construction is seen to the north of the previous one.

These porcelain and ceramic pieces found from the Sarlag Hill can be classified into two main types such as

porcelain and pottery. As far as we can identify, some of these pieces belong to Jun ware and Longquan Yue Yao of Song dynasty ceramics. Such Song and Yuan dynasty ceramics were initially found in the ruin of Doit, Shaazan (It means ‘porcelain in Mongolian) town, Shaazant and Mazar, etc.

According to the research of archeologist B. Boldkhuyag, “There is plenty of evidence, proving that certain types of porcelains and potteries were produced in Kharkhorin from those that were gathered from archeological excavations made at different times at that site. After some analysis, we drew a conclusion that two types of ceramics were commonly produced. They were Longquan Yue Yao to meet the demands of the public and Jun ware to fulfil the demands of royals. As for Jun ware, these types of porcelain pieces were found in numbers, with some appearing to be defects of mass production, even though they were dedicated to royals. Thus, we consider that these two types of porcelain were produced in this very city.’ Whereas quality test by bamboo stick traces is clearly seen on some porcelain pieces found from Sarlag Hill. This proves they were produced at this site. The same porcelain pieces with bamboo stick test were found during the excavations at Kharkhorin city sites according to a scientific article by a German researcher, Anna Hessner.

As we trace this settlement through historical source texts, a Chinese traveller Zhang de hui, who travelled to Mongolia in 1247, witnessed harvesting and manufacturing settlements in the Burgatai and Orkhon Rivers and Khorin valley.

On his travel to Kharkhorin city, he visited Ugii Nuur Lake and ‘Chilen balgas’ (its present name) on its west side. He recorded, ‘On the straight west side of the above-mentioned lake we came across an ancient ruin from the Khitan period.



2014/12/14

“Дээр дурдсан нуурын чанх баруун талд киданчуудын үед босгосон бас нэг эртний туурь тааралдсан бөгөөд түүнээс баруун тийш хараа сунгавал лавтайяа 100 ли баймаар нэгэн хөндий, эргэн тойрноор нь хаяалсан олон уултай агаад хойд талынх нь уулс нарсан ойгоор битүү хучигдаж. Тэр их хөндийг зүсэн Холинъ гол урсах агаад эргээр нь нов ногоон улиас, бургас, удган модод багширна. Тэр газрын оршин суугчид газар тариалан эрхэлж, хүнсний ногоо, шар будаа, улаан буудай тарьж ургуулах бөгөөд олон тийш усалгааны суваг татжээ...” гэхчлэн маш тодорхой тэмдэглэл үлдээжээ. Тус суурин Чжан Дэ Хуэй дайран өнгөрсөн Морин толгойн суурин байх магадлалтай байна. Учир нь Сарлаг толгойн баруун урд байх нэгэн жижиг толгойг нутгийнхан одоог хүртэл "Морь татдаг толгой" буюу "Морин толгой" хэмээн нэрлэсээр иржээ. Бид Сарлаг толгойн орчмын газар усны нэрсийг судлан тодруулах явцдаа уг суурины урд 800 метр зайд Морь татдаг толгой, хойно нь 1,5 километр зайд Мэлхий толгой зэрэг газар усны нэр бүртгэгдсэн бөгөөд бидний урьдчилан таамаглаж байгаагаар XIII-XIV зууны үед Орхон голын зөөлөн урсгалт салааг түшиглэж байгуулагдсан гар урлал, газар тариалангийн чухал ач холбогдолтой газар байж, сууринд ваар сав шатаах зуух ажиллаж зарим төрлийн шаазан эдлэлийг үйлдвэрлэж байсан болов уу хэмээн таамаглаж болохоор байгаа бөгөөд цаашид нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай газар юм.

When facing the west direction from that ruin, one can see a valley, approximately 100 li, surrounded by mountains, with its northern mountains covered by pine forest. Huolinguol River with green aspen trees, brushwood and stragglers on its banks, flows like it is cutting through the valley. Inhabitants of this area harvested grains, vegetables and millet and dug water channels in many directions...’ What we discovered today is түүнээс?? probably ‘Morin Hill Settlement’, which was visited by Zhang de hui. There is a small hill named by locals as ‘Morin Hill’ for it was the start line of horse racing on the south-western side. As we research local geographical names, ‘Morin Hill’ locates 800 meters to the south of the settlement and ‘Melhii Hill’ locates 1.5 km to the north. Based on these facts, we conclude that this settlement was a significant place for harvesting and manufacturing, where the Orkhon River flows smoothly. We have presently formed a hypothesis that the settlement had kilns for producing various porcelain potteries. It requires further specific research to prove the fact in a well-established manner.

### TRAVEL ROAD STATIONS OF THE GREAT MONGOL EMPIRE PERIOD

By Sh. Munkhbaatar, a researcher of the Institute of Chinggis Khaan Heritage and Culture

During Chinggis Khaan’s military campaigns Mongols explored new roads and routes and established official stations along these for the sake of communication and logistics such as the fastest transmission of military intelligence news, transportation of army weapons, food and so on. After the enthronement of Ögedei as an emperor, the system of station posts was more refined and developed and therefore, the central part of the Mongolian Empire was well connected with its west and east wings.

Ögedei Khagan newly established thirty-seven permanent stations and ordered armed forces to safeguard them. It is recorded in a historical document that such a station had about 20 servicemen such as penman or clerks, way-man, post rider, guide, peasant, horse-breeder, house smith or builder, curer, fireman, waterman, manager, inspector and so on. They served there together

### МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ӨРТӨӨ ЗАМ

Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Ш.Мөнхбаатар

Чингис хааны байлдан дагууллын үед шинэ зам гарган өртөө, улааг тагнуулын мэдээ дамжуулах, зэр зэвсэг зөөх, цэргийн хоол хүнснийг хангах зэргээр ашиглаж байв. Өгэдэй хаан ширээнд суусны дараа өртөөний нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, Монгол гүрний төвийг зүүн, баруун жигүүртэй холбосон байна.

Өгэдэй хаан 37 суурь өртөөг шинээр байгуулж мянгатуудаар хамгаалуулан аюулгүй байдлыг хангасан байдаг. Монголын нууц товчоонд өртөөнд бичээч, замчин, улаач, хөтөч, тариачин,



مەن ھەم ھەممە ھاмау

адучин, балгасчин, хоол хүнс бэлтгэгч, галч, усч, зохицуулагч, хэрэг шийтгэгч зэрэг олон төрлийн албыг 20 улаач гүйцэтгэнэ гэж бичжээ. Эдгээр албыг улаач нар өрх бүлийн хамт ирж алба хаадаг байна. Нэг өрхийн 4 хүн гэж үзвэл нэг өртөө 80 орчим хүнтэй байсан бололтой. Агтач нар өртөөний мал сүргийг хариулах үүрэгтэй. Замчид гүүр барих, бартаа саадыг зайлуулах ажлыг гүйцэтгэнэ. Балгасчин нар томоохон суурин өртөөний албан хэрэгцээний барилга байгууламж, сүм хийд, худалдааны газрыг барьж байгуулна. Усч хэмээх үүрэг бүхий хүмүүс тухайн бүс нутагт буй цэвэр усны хэрэгцээг хангах, худаг малтах, суваг, шуудуу татах, өртөөний мал сүрэгт хэрэгцээтэй ус гаргана. Галч нар модлог ургамал, аргал, хомоолыг түүж түлшний нөөцийг хангана. Өртөөний нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй яваа худалдаачдыг хянагч, зохицуулагч нар цагддаг байжээ.

Өртөө бүрт ижил дүрэм үйлчлэх боловч өртөө бүрийн хүн ам, мал сүрэг, бүтэц зохион байгуулалт өөр өөр байсан бололтой. Тухайлбал; гол зангилаа газарт буй өртөөнд хүн ам олноороо сууж байсан төдийгүй, албанд унах морь, шүүс хонийг ихээр гаргах хүчин чадалтай байжээ. Өөрөөр хэлбэл өртөө нь гол зангилаа газар буй эсэхээс хамааран том, жижиг хэмжээтэй байв. Өртөө нь байнгын үйл ажиллагаатай хоорондын зай ч мөн харилцан адилгүй байв. Судрын чуулганы мэдээгээр “Таван фарсанг бүрт нэг яам бий” хэмээн өгүүлдэг. Угтаа 28-35 км тутам нэг өртөө байсан мэт. Уг мэдээ бүх өртөөний хэмжээг яг заасан гэж ойлгож болохгүй юм. Монголын өргөн уудам нутагт байгуулсан өртөөдийн онцлог нь ердийн хөсөг байв. Тиймээс өртөөд нь усны гарц, малын бэлчээр, байгалийн онцлог зэргээс шалтгаалан хол, ойр зайтай оршино. Мөн жилийн дөрвөн улирал ээлжилдэг Евразийн эрс тэс уур амьсгалд дасан зохицож улирлаасаа шалтгаалан эзэмшил нутаг дотроо нүүдэллэн аж төрж байв.

Монголын Эзэнт улсуудыг холбосон өртөөний тогтолцоо өрнө, дорно дахины ард түмний хооронд харилцаа холбоо, худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын гүүр болж байв. Тиймээс өртөөгөөр тасралтгүй хүн, ачаа хөсөг цувж байсан мэдээ бий. Өртөө нь засаглалын хүчин чадалтай шууд хамааралтай байдаг. Хүчирхэг төр оршиж буй бол өртөө улааны тогтолцоо тогтвортой байж түүгээр мэдээлэл, худалдаа арилжаа тасралтгүй хийгдэхийн сацуу харьяат улс орнуудаас ирэх алба татвар хугацаандаа ирдэг байжээ.

with their family. If we estimate there were at least 4 members in a family, then this would mean there were approximately 80 persons at one station. Horse-breeders took care of livestock while the way-man was responsible for building bridges and removing various barriers on the roads. Builders had to construct buildings, temples and trade places, etc., whatever was needed for the official functioning of the station. Likewise, the waterman was responsible for the freshwater supply of the station and would dig a new well or channel for watering crops and livestock. The fireman supplied all firewood and dung, etc. Lastly, those managers and inspectors checked the permissions of traders and travellers within the boundary of their station.

Although all stations functioned and were regulated by the same rules, there were some differences between various stations in terms of population, livestock and structure. The size of a station depended on its location for example, whether it was in a significant hub or not. All stations operated on a regular basis. Distance between stations also varied depending on road conditions. According to the ‘Compendium of Chronicles’ (the *Jāmi’ al-tawārikh*) by Rashid al-Din, ‘there was one station in every five parasangs’. This means the distance between two different stations was around 28-30 km and it seems logical because the distance capacity of an average high-speed horse is around 30 km. However, we should not take for granted this information as being precise. Characteristics of stations and roads throughout Mongolia’s large territory indicated that they were dedicated to horse or camel rides or mounted carts. Thus, distances between stations were sometimes a little longer, sometimes shorter than this average measurement depending on the availability of freshwater, livestock grass conditions and natural characteristics. Furthermore, Mongols were accustomed to moving within their owned territory in accordance with four seasons, which are radically different from each other in terms of weather conditions.

This system of travel road stations of the Great Mongol Empire served as a communication, economy, science and cultural bridge between western and oriental peoples. These stations had direct dependence on State power. When the State ruling was powerful, the system of road stations was firm and steady therefore, trade activities were uninterrupted, important messages and news were quickly transmitted and various taxes from various vassal states were collected on time.

Parasang- Persian walking distance measurement.  
1 parsang = 5549 m. 5 parsang=27745 m or approximately 28 km

## ЧИНГИС ХААНЫ ДҮҮ НАРЫН ХАРЬАТ УЛС

Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Б.Мягмаржав

Чингис хаан тархай бутархай олон овог, аймгийг нэгтгэж, Их Монгол улсыг байгуулахад түүний дүү нар гол түшиг тулгуур болж, их хэргийг хамтдаа бүтээлцсэн билээ. Энэ тухай Юань улсын сударт: “Хаантан өгүүлрүүн: Бэлгүдэйн хүч, Хасарын харвалгаар би тэнгэрийн доорх улсыг эзэлсэн болой” гэж тэмдэглэсэн байдаг. 1206 онд Их Монгол улсыг байгуулсны дараа Чингис хаан өөрийн хөвгүүд, дүү нартаа “хувь хувилж” өмч нутаг олгохдоо дүү нартаа гол төлөв зүүн хэсгийн нутаг бэлчээрийг хуваарилсан байна.

Хасарт 4000 иргэн (хожим нь хасч 1400 болгосон), Хөлөн нуур, Хайлаар гол, Эргүнэ гол орчим нутгийг өгчээ. Бэлгүдэйд 1500 иргэн хуваан өгч, Хэрлэн, Ононы дунд хэсгийн нутагт суулгажээ. Хачигуны хөвгүүн Алчидайд (хувь хувилах үед Хачигун нас барсан байв) 2000 иргэн хуваан өгч, Буйр нуураас өмнөх Олгой гол, Хулуур гол (одоогийн Булгар гол) орчмын нутагт суулгажээ. Тэмүгэ отчигин болон Өүлэн эхэд нийт 10000 иргэн өгсөн бөгөөд Халх гол орчим нутаглаж, удалгүй түүний хүч их Хянган давааны зүүн хүртэл өргөжжээ. “Монголын Нууц Товчоон”-ы 252 дугаар зүйлд: “Чингис хаан зөвшөөн, зарлиг болруун: Хасарын ураг нэгнээ мэдүүл! Алчидайн ураг нэгнээ мэдүүл! Отчигины ураг нэгнээ мэдүүл! Бэлгүдэйн ураг нэгнээ мэдүүл!...” гэснээс үзвэл дүү нарынхаа гэрээс тус бүр нэг хүнийг гэрийн дээд ноёлогч болгожээ. Ингэснээр Их Монгол улсын дотор Чингис хааны дүү нар болон тэдний хойчсын захиргаан дахь харьцангуй бие даасан жижиг “улс” тогтжээ.

Алтан улсыг байлдан дагуулсны дараа, Чингис хааны дүү нар суурин иргэдээс нэлээдгүй олон өрх хуваан авсан байдаг. Юань улсын үед Чингис хааны дүү нарын улсын дээд ноёлогчдоод соёрхсон Хятад газрыг нь үндэс болгож, ван цол шагнажээ. Хасарын өмчилсөн хятад газар нь Бань Ян чөлгөө (般阳路, одоогийн БНХАУ-ын Шандун мужийн Зи фү хот) бөгөөд энэ газрыг эрт үед Чи (齐) хэмээн нэрлэдэг байсан учир Хасарын ач Бабушаас эхэлж Чи ван (齐王) өргөмжилж, Хасарын улсын ноёлогч болсон байна. Бэлгүдэйн өмчилсөн хятад газар нь Гуан Нинь Фү (广宁府, одоогийн БНХАУ-ын Ляонин мужийн Бэй Жэнь шяний орчим) бөгөөд Бэлгүдэйн ач Зуутаас эхэлж Гуаннин (广宁王) ван өргөмжлөгдөж, Бэлгүдэйн улсын ноёлогч болжээ. Хачигуны өмчилсөн хятад газар нь Жи Нань чөлгөө (济南路, одоогийн БНХАУ-ын Шандун мужийн Жи Нань хот) бөгөөд Хачигуны хойчсын ноёлогчид Жинань ван (济南王) өргөмжлөгджээ. Отчигины эрх нөлөө Их Хянган давааны зүүн дэх Лияо дун (辽东)-д байсан учир ноёлогчид Лияо ван (辽王) өргөмжлөгджээ. Чингис хааны дүү

## CHINGGIS KHAAN'S YOUNGER BROTHERS' SUBJECTS ESTABLISHED AS SMALL KINGDOMS

By B. Myagmarjav, a researcher of the Institute of Chinggis Khaan Heritage and Culture

Younger brothers of Chinggis Khaan were serving like strong pillars for uniting scattered Mongol tribes and establishing the Great Mongol Empire. It is recorded in the History of Yuan (Yuán Shǐ) as follows: ‘Thus Khagan said, I conquered all peoples under the heaven by the strength of Belgutei and shootings of Khasar’. Chinggis Khaan bestowed some subjects and lands, mostly the eastern lands of the empire, to his sons and younger brothers right after the establishment of the Great Mongol Empire in 1206.

He bestowed lands of Hulunbuir, Hailar River and Ergune River along with 4000 subjects (later this number was reduced to 1400) to Khasar; mid area of Kherlen and Onon Rivers along with 1500 subjects to Belgutei; lands around Olgoi Lake and Khuluur River (present Bulgar River) to the south of Buir Lake along with 2000 subjects to Alchidai, a son of Khachigun (as at the time Khachigun had passed away). Temüge Otchigon (youngest brother) and Mother Üülen were bestowed 10,000 subjects and lands nearby the Khalkha River. Soon after, his power was increased and his land was extended up to the eastern part of the Greater Khingan Range (Da Hinggan Range). As it is written in ‘Article 252, the Secret History of the Mongols’, ‘Chinggis Khaan said as he accepted the request, ‘Khasar family, submit one of yours! Alchidai family, submit one of yours! Otchigon family, submit one of yours! Belgutei family, submit one of yours!’. This indicates the appointed leaders among each of his younger brothers’ subjects. Thus, this was the foundation of comparatively independent ‘small kingdoms’ of Chinggis Khaan’s younger brothers and their successors within the Great Mongolian Empire.

After conquering China, Chinggis Khaan’s younger brothers distributed among themselves a considerably large number of subjects from those settled citizens. Later, supreme leaders of Chinggis Khaan’s brothers’ kingdoms were conferred ‘Wang’ titles based on what part of Chinese land was conferred to them. Chinese territory owned by Khasar was named Banyang (般阳路, present Zibo, Shandong, China) and this was named ‘Qi’ (齐) from ancient times, and hence, Babush, who was a grandson of Khasar, was conferred as ‘Qi Wang’ (齐王) and decreed as Noyon (Ruler) of Khasar’s kingdom. Belgutei’s owned land in China was Guangningfu (广宁府, present Beizhen City, Liaoning Province, China), and therefore, Zuut, a grandson of Belgutei, was conferred as ‘Guangning Wang’ (广宁王) or king of Belgutei’s kingdom. Khachigun’s land in China was Jinan (济南路, present Jinan city, Shandong Province, China) and hence, his successor was conferred as ‘Jinan Wang’ (济南王). As Otchigon’s land in China was Liaodong (辽东), located to the east of the Greater Khingan Range, his successor was

Чингис хааны дүү нарын харьцангуй бие даасан жижиг улсууд

нарын улсын ноёлогчид нь энэхүү ван цолыг XVI зууныг хүртэл үе улиран тасралтгүй залгамжилж байсан нь сурвалжийн мэдээгээр батлагддаг. Тэд (Чингис хааны дүү нарын хойчис) монгол болон хятад сурвалжуудад оннигууд, онлигууд, оннид гэх зэргээр тэмдэглэгдсэн нь тэдний “ван” цолыг зааж буй хэрэг юм. Хятадын ван цолыг монгол хэлэнд “онг” хэмээн буулгадаг.

Хятад дахь Монголын ноёрхол унасны дараа Монгол нутагтаа эргэж ирсэн Хубилайн угсааныхан хийгээд Аригбөхийн угсааныхныг түшиглэсэн Ойрадууд хэмээх улс төрийн хоёр том хүчин оршиж байсан бол XV зууны дунд үеэс Их Хянган давааны араар нутаглаж байсан Чингис хааны дүү нарын хойчис вангууд улс төрийн хэрэгт ихээхэн идэвхтэй оролцож зарим үед төрийн хэргийг удирдах хэмжээнд хүрчээ. Тухайлбал, Хасарын угсааны Болонай ван, Бэлгүдэйн угсааны Молихай ван, Хачигуны угсааны Доголон тайж нарыг нэрлэж болох юм.

XVI зууны дунд үеийн Урианхан (Урианхан 3 харуул буюу Тайнин харуул, Доён харуул, Фү Юй харуул) –ы бутралаар Отчигины хойчсын ноёлж байсан улс задарч, Халх, Цахар Хорчин, Харчинд хуваагдан тархжээ. Тиймээс XVII зууны монгол сурвалж бичгүүдэд Хасар, Бэлгүдэй, Хачигуны үр удам тодорхой тэмдэглэгдэж, харин Отчигины удам угсаа тоймтой тэмдэглэгдээгүй байна. 1480-д оноос Батмөнх даян хаан улс төрийн хагарал бутралаас үүдэн тарж бутарсан улсаа дахин эмхлэн байгуулах үед дээр дурдсан вангуудын хойчис Даян хаанд хүчин зүтгэжээ.

XVII зууны эхэн үеэс Монголын улс төрийн гадаад, дотоод нөхцөл байдал дахин өөрчлөгдөв. 1616 оноос Монголын зүүн өмнөд хэсэгт Хожуу Алтан улс сэргэн мандаж хатуу, зөөлөн олон аргаар хөрш зэргэлдээ улс орнуудаа эзлэн авсан байдаг.

Хасарын хойчсын ноёлол дахь аймгуудыг Хорчин түмэн гэдэг. Хорчин түмний нэр Монгол сурвалжуудад олонтаа тэмдэглэгдсэн байх бөгөөд Хорчин аймгийн ноёд хамгийн анх Манжид дагаар орж, үе улиран Манжийн хааны угсаатай ураг барилдсан тул тэдний байр суурь бусад монгол язгууртнаас нэлээд өндөр, газар нутгийн цар хүрээгээр өргөн байжээ. Хасарын угсааныхныг Хорчин, Ар Хорчин, Нуун Хорчин гэхээс гадна, мөн Дөрвөн хүүхэд, Урад, Муумянган, Хошуудууд (Хөхнуурын) гэдэг.

Бэлгүдэйн хойчсын ноёлол дахь Онлигуудын их түмэн нь XVI зууны сүүлчээр авга, авга нар аймаг болжээ. Тэдний зарим хэсэг ээлж дараалан Чин улсад дагаар орсон тул Чин улсын зүгээс тэдэнд Авгын баруун, зүүн гарын хошуу; Авга нарын баруун, зүүн гарын хошуудыг байгуулан Шилийн голын чуулганд суурьшуулсан нь одоогийн ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Авга хошуу юм.

Хачигуны хойчсын ноёлол дахь аймаг Чин улсад дагаар орж, Оннигууд нэрээрээ зүүн, баруун хоёр хошуу болон байгуулагдаж, Зуу-Удын чуулганд суурьшуулсан нь одоогийн ӨМӨЗО-ны Улаан хад аймгийн Оннигуд хошуу болно.

conferred as ‘Liao Wang’ (辽王). Thereafter, these rulers of Chinggis Khaan’s brothers’ kingdoms had inherited to succeed their Wang titles up to the 16th century. They were mentioned in both Mongolian and Chinese historical sources as ‘Ongnig’, ‘Onglig’, and ‘Ongnid’, etc. These words refer to their ‘Wang’ title as Mongols name Chinese ‘Wang’ title as ‘Ong’.

After the fall of Mongol rule in China, there were two major political powers in Mongolia. Those were (1) descendants of Kublai Khaan, who returned after the downfall of the Yuan Dynasty, and (2) Oirats, who were dependent on descendants of Ariq Böke. However, those Wangs from the backside of the Greater Khyangan range, who were descendants of Chinggis Khaan’s brothers, became politically active from the middle of the 15th century onwards and even ruled Mongolia for some time. For instance, we can mention Bolonai Wang, a descendant of Khasar, Molihai Wang, a descendant of Belgutei and a prince Dogolon, a descendant of Khachigun.

In the middle of the 16th century, a kingdom ruled by descendants of Otchigoin collapsed and was scattered into Khalkha, Chahar, Khorchin and Kharchin due to the chaos of Uraihan (3 Uraihan guards called Taining, Doyon and Fu Yu). Thus, descendants of Khasar, Belgutei and Khachigun are well mentioned, while there is no mention of descendants of Otchigoin in 17th-century Mongolian historical sources.

Descendants of the above-mentioned Wangs became subjects of Dayan Khaan when Mongols were re-uniting under the rule of Batmunkh Dayan Khaan in the 1480s. In the earlier 17th century, both foreign and domestic Mongolian political situations again changed. It is now well-known history that the Later Jin dynasty (1616–1636) regained its power in 1616 and conquered its neighbouring countries through various means such as diplomacy and military campaigns.

Subjects of Khasar’s descendants are called Khorchin people. This name is repeatedly recorded in Mongolian historical sources. For instance, they are mentioned in various historical events in the 15th century as ‘Khorchin Aimag’ according to ‘Golden Navel History’. Nobles of Khorchin submitted to Manchu Qing much earlier than other Mongols and established intermarriage relationships with the Manchu emperor’s family hence, their status was much higher than other Mongol nobles and they owned much larger territories. Descendants of Khasar are Horqin, Ar Horqin, Nuun Horqin, Durvun Huuhed, Urad, Muu Myangan and Hoshut (in Khukh Nuur).

Ongliguud, subjects of Belgutei’s descendants, were named Avga and Avga nar by the end of the 16th century. One by one, they submitted to Manchu Qing Dynasty and were established as Right and Left Banners of Avga; Right and Left Banners of Avga nar in the Xilingol League. This is the present-day Abag Banner of Xilingol Aimag or League, Inner Mongolia, China.

As for Ongnigud, subjects of Khachigun’s descendants, they were established as Right and Left Banners of Ongnigud in Ju Ud League after submitting



Хэдийгээр Чингис хааны дүү нарын хойчсын нутаг гол төлөв одоогийн ӨМӨЗО-нд байх боловч тухайн үед Бэлгүдэйн угсааныхны ихэнх нь уугуул нутаг болох Хэрлэн, Ононы дундурсгалын нутаг хавиар үлджээ. Мөн Хасар, Хачигуны үрсээс Халхын нутаг руу орж нутагласан цөөн бус тохиолдол бий ажээ. Тэднийг нийтэд нь харьяат тайж болгосон бөгөөд ХХ зууныг хүртэл үе улиран тасралтгүй зэрэг залгамжилсан нь архивын баримтад тодорхой тэмдэглэгдсэн байдаг. Халх дахь Хасарын угсааны тайж нарыг “Хорчин харьяат тайж”, Бэлгүдэйн угсааны тайж нарыг “Авга харьяат тайж”, Хачигуны угсааны тайж нарыг “Оннигуд харьяат тайж” гэдэг байв.

### ГУРВАН НУУРЫН ДОМОГ

#### (ЧИНГИС ХААНЫ МЭНДЭЛСЭН ГАЗРЫН ТУХАЙ)

##### А хувилбар

Хэнтий аймгийн нутагт буй Гурван нуурын хамгийн баруун талын нуур нь Чингис хааны хатан сууж байсан гэрийн буурь гэдэг. Дунд талын нуур нь Чингис хааны төрсөн газар ба түүний гэрийн буурь гэдэг ажээ. Мөн зүүн захын нуурыг Чингис хааны хөвүүний гэрийн буурь гэдэг ажээ. Энэ гурван нуураас урагш нэлээд өндөрлөг газар бяцхан нуур байх бөгөөд дотор нь Чингис хааны тогоо байсан гэдэг ажээ.

##### Б хувилбар

Чингисийн төрсөн нутаг гэлцдэг Гурван нуурын зүүн нуурыг ингэж нэрлэдэг. Чингисийг төрөх үед эхэд нь цагаан адууны махаар шөл уулгаад дэлүүг булсан тул Дэлүүн нуур хэмээдэг болсон гэнэ. Дунд нуур нь өр дундаа аралтай, тэр арал нь дүв дүгрэг, дээрээ тэгш, өр дундаа бяцхан хонхортой ажээ. Тойрон битүү усаар хүрээлэгдсэн тэр арлын өр дэх хонхор нь урьд халуун нурам байсан ба Чингис хааны гэрийн буурь байсан гэдэг домогтой. Баруун давстай нууранд нь Чингис хааны нялх биеийг угааж болгосон гэж домоглодог бөгөөд иймд Болдог гэж нэрлэсэн байна. Ингээд Дэлүүн болдог гэдэг нэр үүсжээ.

##### В хувилбар

Гурван нуур эрт цагт байгаагүй гэнэ. Харин одоогийн Гурван нуур бол Есүхэй баатрынхны гэрийн буурь аж. Есүхэй баатрын хатан Өүлэн үжин ууган хүүгээ энд төрүүлжээ. Тэр хүү нүдэндээ галтай нүүрэндээ цогтой, бадриун биетэй агаад баруун гартаа шагайн чинээ нөж атгаж гарчээ. Монголчууд төрсөн эхэд хонины махаар шөл уулгаж тэнхрүүлдэг заншилтай боловч энэ удаа тэгж болохгүй байв. Учир нь сая төрсөн хүү нэгэнт гартаа нөж атгасан бас морин цагт мэндэлсэн тул яавч жирийн

to Manchu Qing Dynasty. This is the present-day Ongniud Banner of Ulaan khad (Chifeng) league, Inner Mongolia, China.

However, most of the territories owned by descendants of Chinggis Khaan's brothers were in present-day Inner Mongolia and nearly all of the descendants of Belgutei continued living in their native land around the middle stream of the Kherlen and Onon Rivers. Moreover, it was not just a few times that some of Khasar and Khachigun's descendants moved into Khalkha territory in the long course of history. They were all exalted as 'prince subjects' and inherited this title from generation to generation up to the earlier 20th century. Descendants of Khasar in Khalkha were named as, 'Khorchin prince subject'; descendants of Belgutei in Khalkha were named as, 'Avgga prince subject' and descendants of Khachigun were named as, 'Ongnigud prince subject'.

### A MYTH: CHINGGIS KHAAN LEGENDS OF THE THREE LAKES

#### (ON BIRTHPLACE OF CHINGGIS KHAAN)

There are three lakes, closely related to Chinggis Khaan's life stories, in the present Khentii Province, Mongolia. There are several versions of myths related to these lakes and Chinggis Khaan among locals of Ulaan khad (Chifeng) league, Inner Mongolia, China.

However, most of the territories owned by descendants of Chinggis Khaan's brothers were in present-day Inner Mongolia and nearly all of the descendants of Belgutei continued living in their native land around the middle stream of the Kherlen and Onon Rivers. Moreover, it was not just a few times that some of Khasar and Khachigun's descendants moved into Khalkha territory in the long course of history. They were all exalted as 'prince subjects' and inherited this title from generation to generation up to the earlier 20th century. Descendants of Khasar in Khalkha were named as, 'Khorchin prince subject'; descendants of Belgutei in Khalkha were named as, 'Avgga prince subject' and descendants of Khachigun were named as, 'Ongnigud prince subject'.

##### Version A

It is said that out of the three lakes, the western one was a base of a ger for Chinggis Khaan's queen while the middle one was the birthplace of Chinggis Khaan, himself and a base of his ger. Then, the east lake is said to be again, a base of Chinggis Khaan's childhood time ger. There is a small lake, which locates to the south of these three lakes on considerably high land and locals believe that Chinggis Khaan's cauldron was there.

##### Version B

To the east of three neighbouring lakes, regarded as the birthplace of Chinggis Khaan. At the time of Chinggis Khaan's mother giving birth to him, a soup of 'a white horse' meat was cooked and its milte (spleen) was buried there. This was how the lake

Чингис хааны  
мэндэлсэн  
газрын  
тухайн  
домог

ᠠᠨᠢᠨ ᠮᠡᠳᠡᠬᠦᠢᠨ ᠪᠤᠯᠠᠨ

хүн биш нь тодорхой. Ингээд Есүхэй баатар «баатар хүү төрлөө» хэмээн ихэд бэлгэшээн баярлаад тэмдэггүй шарга гүү гарган Өүлэн хатандаа шөл уулгажээ. Тэр гүүнийхээ дэлүүг газарт булж тайсан байна. Тэгээд уг газар нь "Дэлүүн болдог" нэртэй болсон юмсанж. Далаад он хүртэл дунд нуурын хойт эргээс дотогш хориод метрт уснаас нэлээд дээш гарсан гэрийн бууриас яльгүй томхон ганц дугуй арал (болдог) байдагсан. Түүнийг нутгийнхан "Дэлүүн болдог" гэж нэрлэдэг билээ. Тэр арал усны түвшин дээшилснээс эдүгээ алга болжээ.

Энэ нутгийнхан одоо хүртэл Чингисийн сэдэвтэй, байгалийн онцлогийг тусгасан ая, хэмнэл, сайхантай нэгэн буриад дуу дуулдаг.

Тэрэнги (Тэрэлж мод) л модон чимэглэлтэй  
Тэмүүжин төрсөн Дэлүүн болдог  
Тэсэшгүй тэмцлийн эцэст  
Тэнгэрхэн монгол минь дэгжиж л байна  
Шилмүүс л модон чимэглэлтэй  
Чингисийн төрсөн Дэлүүн болдог  
Ширүүхэн тэмцлийн эцэст  
Шинэхэн монгол минь дэгжиж л байна.

Нэлээд хожуу үед зохиогдсон байлаа ч ард түмэн их хаан, түүний гавьяа зүтгэлийг мартаагүй өдий хүрсэн ажээ. (Эл хувилбарыг «Хөдөлмөр» сонинд Ц. Намсрай хэвлүүлжээ).

#### Г хувилбар

Балж голын хойд этгээдэд Шурагзай (энэхүү Шурагзай хан уулыг Шурагтай ч гэдэг байжээ. Тэгтэл тэр хавийн Угтамын хийдийн хувилгаан лам эл Шурагзай хан уулыг миний төрсөн нутаг гэж зарлаад Баянхаан уул гэх болгосон гэдэг) хан хэмээх нэгэн уул бий. Тэрхүү Шурагзай хан уулын зүүн хойт ар болох газарт Бурхант хэмээх ганц гозгор хадтай уул буй. Мөн Шурагзай ханы зүүн өмнө Онон, Балж хоёр голын хооронд Баян-Овоо хэмээх модтой нэгэн уулыг Чингис хаан тайж явсан уул гэдэг.

Тэрхүү Баян-Овооны зүүнээс бяцхан хойгуур зүүн хойноос бяцхан өмнүүр ойр ил Болдогийн эрэн толгой нэртэй өвөртөө эрэн толгойн өмнүүр зүүн өмнөөс бяцхан хойгуур ил газраа зүүн хойноос баруун өмнө цувсан Гурван нуурын (Зүүнээс дундхыг хүртэл 200 алд хэр газар дундхаас барууныг хүртэл 150 алд газар ажээ) Зүүн нуурт нь Чингис хаан төрөөд эх нь адууны дэлүүгээр шөл ууснаар Дэлүүн нуур гэдэг.

Дунд нуур нь өр дундаа аралтай, тэр арал төв төгрөг дээрээ тэгш бас өр дундаа бяцхан хонхортой, тойрон битүү усаар хүрээлэгдсэн тэр арлыг төсөөлбөл хөндлөн гудас хориод алд хэр. Жараад жилийн урьд урдах хонхор нь юм түлэгдэх халуун нурам байсан гэнэ. Түүнийг Чингис хааны гэрийн буурь хэмээн хэлдэг.

Баруун давстай нуурт Чингис хааны нялх биеийг угааж болгосноор Болдог нуур нэртэй болсон гэнэ. Зүүн ба энэхүү баруун хоёр нуурын нэр нийлээд Дэлүүн Болдог болсон ажээ. Тэр гурван нуурын өмнө зүгт 500 алдын хэр зайтай өндөрхөн довын орой болох өндөрлөгийн нуур далаад жилийн үед усгүй байсан, түүнд нэг их

came to be named, 'Milte Lake' ('Deluun nuur'). The Middle lake has a small circular island, with a smooth surface and a tiny pit at its centre. It is said that the pit had hot nectar and that it was also a base of Chinggis Khaan's ger. According to myths, baby Chinggis Khaan's body was bathed in the salty west lake and hence, it was named 'Boldog' (Purified). This was the reason why this site was named 'Deluun Boldog' after these events.

#### Version C

In ancient times, there was no lake. There was a base of Yesugei Baghatur's ger at the location of present-day three lakes. His queen Oulen gave birth to her eldest son there. The newly born baby had a fit and healthy body with a magnificent appearance and he was holding an ankle bone size blood clot in his right hand. According to tradition, a newly born mother should be fed mutton soup for refreshment. However, this was an unusual case since the infant was born in 'Horse hour' and holding a blood clot, signs of an extraordinary one. Yesugei Baghatur considered this a sign of a future hero and ordered the preparation of a soup of a light bay mare without any marks.. The milte (spleen) of that mare was buried with certain rituals. From that time, this site was named 'Deluun Boldog' (Milte buried). There was a small circular island ('boldog'), a little larger than a ger base, approximately 20 meters to the south from the north coast of the middle lake. Locals named this island 'Deluun Boldog. This island is submerged due to flooding since the 1970s.

Locals sing a beautiful Buryat folk song related to Chinggis Khaan's birthplace.

Deluun Boldog, Temujin's birthplace,  
Decorated with Ledum flowers and trees,  
Divine Mongolia is gradually developing,  
At the end of unbearable conflicts.

Deluun Boldog, Chinggis's birthplace,  
Ornamented with Pinaceae trees  
Modern Mongolia is gradually rising up,  
At the end of heavy struggles.

Obviously, this song was composed in a much later period. However, this reveals that the Mongols never forget the legacy of their great Khagan. (This version was published in the Labor News («Хөдөлмөр» сонин) by Ts. Namsrai).

#### Version D

There is a mountain called 'Shuragzai Khan' (This was also called 'Shuragtai'. This original name of the mountain was later changed to 'Bayankhaan' by an incarnate lama of Ugtam Monastery, which is located at that site. He claimed that it was his birthplace) on the north side of the Balj River. Then there is another mountain with a single uprising rock called 'Burkhan' at the north-eastern side of Shuragzai Khan. Furthermore, there is still another mountain covered with trees called 'Bayan Ovoo' in between the rivers of Onon and Balj and southeast of the Shuragzai Khan. It is said that this mountain was worshipped by Chinggis Khaan.

тогооны амсар цухуйж байсан гэнэ. Түүнд Чингис хааны тогоо, тулга байсан гэдэг. Энэхүү дөрвөн нуур уужимхан, тойрон битүү модтой. Зүүн нуур буй хонхорт Чингис хааны хөвүүний гэр байсан гэдэг. Тэндээс дунд нуур хүртэл хүн амьтан явж мөр гаргасан зам буй гэдэг.

Баян овооны зүүн хойд зүгт Эрээн Толгойн зүгт ойр Балж голын хойд хөвөөнд намаржаа хэмээх нүцгэн өндөр уулын өвөрт зүүн баруунаа зэрэгцээ улаан, хүрэн өнгийн хоёр чулуу буй. Тэр чулуу хагараад Чингис хааны тамга гарснаар хоёр хэсэг болсон чулуу хэмээн домоглодог. Тэрхүү намаржаа өндөр хэмээх уулыг Чингис хааны намаржиж явсан газар хэмээн хэлдэг.

Ашигласан эх сурвалж:  
 Х.Сампилдэндэв. Эзэн богд Чингис хааны домог оршвой. УБ.,1992

To the north-east side of this Bayan-Ovoo, there is a hill called 'Ereen Tolgoi' and three lakes as if lining up from the north-east to the south-west in front of Ereen Tolgoi. (It is about 200 fathoms from the east lake to the middle one; then approximately 150 fathoms from the middle to the west). The East lake is called 'Deluun or Milte Lake' because when Chinggis Khaan was born, a soup was cooked at that place using the milte (spleen) of a mare for his mother.

The Middle lake has a small circular island, which has a smooth surface with a tiny pit at its centre. Its diameter is approximately twenty fathoms in size. It is reported that there was an ember, which could burn things, in its pit some 60 years ago. This is called a base of Chinggis Khaan's ger.

The body of the baby Chinggis Khaan was bathed in the salty west lake and therefore, was named 'Boldog' (Purified). Then drawing from the names of the east and west lakes together, gave rise to a new name 'Deluun Boldog'. There is still the fourth lake on top of the mound, which locates about 500 fathoms to the south of the three lakes. Some 70 years ago, there was no lake. It is said the edge of a huge cauldron could be seen as it had been buried on that spot and hence, there lay Chinggis Khaan's cauldron and trivet. These four lakes are located in a spacious place surrounded by forest. It is said there is a base of Chinggis Khaan's childhood ger in the east lake and therefore, there is a pathway from the east lake to the middle lake.

On the north side of the Bayan-Ovoo Mountain and nearby Ereen Tolgoi Hill, there is a mountain called 'Namarjaa' (Autumn residing) at the bank of the Balj River. It is said that it was used by Chinggis Khaan as an autumn time residence. There are two parallel stone formations, red and brown in colour, at the front side of the Namarjaa. It is said these two stones came about when a huge stone formation cracked and revealed the seal of Chinggis Khaan.

Чингис хааны  
 өвөрмөц  
 соёлын  
 хүрээгэйн



## ЗОЧНЫ БУЛАН

- ОХУ-ын монголч эрдэмтэн Мелехин Александрт Викторович: “Сүүлийн гурван жилд Чингис хаан ертөнцийг үзэх үзэл ба үйлдэл нэрт намтар зохиол болон Чингис хааны Их засаг зэрэг номыг бичиж дууссан”

## INTERVIEW CORNER

An interview with Mr. Melekhin, Alexandr Victorovich



## ЗОЧНЫ БУЛАН

ОХУ-ын монголч эрдэмтэн Мелехин Александрт Викторовичтой уулзаж, уран бүтээлийнх нь талаар ярилцлаа.

Сайн байна уу?

- Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн үндсэн зорилгын нэг хэсэг нь гадаадын монголч эрдэмтэдтэй хамтран ажиллах тэдний бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах ажил байдаг. Энэхүү ажлаа тус хүрээлэнгээс анх удаа эрхлэн хэвлүүлж буй танин мэдэхүй, мэдээллийн сэтгүүлийн зочны булангийн хүндэт зочны ярилцлагад таныг урьж оролцуулж байгаадаа баяртай байна. Та өөрийнхөө талаар товч танилцуулна уу.

- Намайг Мелехин Александр Викторович гэдэг. 1972-1978 онд МУИС-ийн Хэл бичгийн факультетын монгол хэлний ангид суралцаж, монгол хэлний орчуулагч мэргэжлээр төгсөв. ЗХУ-ын радио, телевизийн хорооны монгол хэлээр нэвтрүүлэх редакц, АПН-ны «Новости» хэвлэлийн газрын Дорно дахины редакцийн монгол хэлээр ном товхимол бэлтгэж гаргадаг хэлтэс, хэвлэл мэдээллийн бусад газруудад ажиллаж 2012 онд тэтгэвэрт гарлаа.

- Та орчуулгын ажлаа хэзээнээс эхэлсэн бэ?

- Өнгөрсөн зууны 80-аад онуудад Москвагийн «Художественная литература» хэвлэлийн газраас «Монголын уран зохиолын номын сан» гэдэг цуврал 25 боть ном эрхлэн гаргасан юм. Тэр хэвлэлийн газрынхан, тухайлбал, Монголын яруу найргийг орчуулж байсан Геннадий Борисович Ярославцев намайг Монголын орчин үеийн яруу найргийг сонирхож байгааг мэдээд, Монголын яруу найргийн гурван ботийг бэлтгэхэд (шүлгийг сонгож аваад, мөрийн орчуулгыг хийхэд) оролцуулсан юм. Тэр «Номын санд» зориулж Д.Сэнгээгийн «Аюуш» туужийг шинээр орчуулжээ. Ингэж л миний орчуулгын ажил эхэлсэн дээ.

-Таныг Ноён хутагт Данзанравжаагийн гүр дууллыг ЗХУ-д анх удаа орчуулсан гэж сонсон.

- Миний багш Геннадий Борисович Ярославцев бид хоёр Данзанравжаагийн гүр дуулал, сургаалын зохиолыг судалж уран сайхны орчуулгыг хийж, 1988 онд Москвагийн «Художественная литература» хэвлэлийн газраас гаргаж байсан «Дорно дахины цоморлигт» хэвлүүлсэн.

-Монголын түүхийн сурвалж, ном зохиолуудыг орос хэлэнд орчуулсан тухайгаа ярина уу?

1987 онд Г.Б.Ярославцев бид хоёр Улаанбаатарт хүрэлцэн ирж, Монголын уран зохиолын орчуулагчдын Олон улсын бага хуралд оролцсон.

## INTERVIEW CORNER

An Interview with Mr. Melekhin, Alexandr Victorovich

Good afternoon!

- Cooperating with foreign scholars in Mongolian Studies and promoting their works is a part of the main objectives of the Institute of Chinggis Khaan Heritage and Culture. I am pleased to invite you to be an honourable guest on the interview page of our first educational journal. Would you please, briefly introduce yourself?

- My name is Melekhin, Alexandr Victorovich. I studied Mongolian language courses at the Department of Linguistics, the National University of Mongolia for academic years from 1972 to 1978. I graduated as a Mongolian language translator. Then I worked in the 'Mongolian broadcasting section' of USSR Broadcasting Radio and Television as a translator, Section of the Oriental Countries of the 'Novosti' Printing (АПН-ны) as a staff for Mongolian language publications and many other media field organisations until I retired in 2012.

- How did you start your major translation works?

- In the 1980s, last century, 'Art of Fictions' (Художественная литература) Publication of Moscow published 25 serial volumes on 'A Bibliotheca of Mongolian Literature'. I had an opportunity to participate in preparing three volumes of Mongolian Poems (choosing poems and translating those lines). Iaroslavtsev Gennadii Borisovich, who was a chief translator for Mongolian poems had discovered that I was interested in modern Mongolian poems and allowed me to participate in that work. For example, I translated 'A Story of Ayush' by D. Sengee for this 'Bibliotheca'. This was how I started my translation works.

- I heard that you translated 'Lines of Direct Experience' by Noyon Khutagt Danzanravjaa and it was the very first of Danzanravjaa in the USSR?

- My mentor Iaroslavtsev Gennadii Borisovich and I together studied and translated some of Noyon Khutagt Danzaravjaa's poems such as 'Lines of Direct Experience' in Russian and published them in 'the Oriental Collections', 1988, by 'Art of Fictions' of Moscow.

- Would you, please, introduce your Russian translations of Mongolian historical texts and source works?

- In 1987, G. B. Iaroslavtsev and I participated in the 'International Conference of Mongolian Literature Translators', held in Ulaanbaatar. During the sessions of this conference, a plan regarding celebrating the 750th anniversary of the Secret History of the Mongols in 1990 was once mentioned. Since then we decided to start immediately with an artistic translation of the Secret History of the

Өв соёлын хүрээлэн  
 Чингис хааны  
 өв соёлын  
 хүрээлэн

Тус бага хуралд болсон хэлэлцүүлгийн үеэр 1990 онд тэмдэглэх «Монголын нууц товчоон» зохиогдсоны 750 жилийн ойн тухай цухас ярилцсан. Түүнээс хойш Г.Б.Ярославцев бид хоёр «Монголын нууц товчооны» уран сайхны орчуулгыг хийхээр шийдэн, ажилдаа орсон юм.

Би «Монголын нууц товчоон»-ыг бүтнээр нь орчуулан тайлбар хийж, Г.Б. Ярославцев яруу найргийн хэсгийг шүлэглэв. 1990 он гэхэд орчуулга маань бэлэн болсон гэвч түүнийг хэвлүүлж чадсангүй. Тус орны эдийн засгийн хүндрэлээс болоод Оросын хэвлэлийн газрууд үйл ажиллагаагаа цомхотгож, зарим нь ажлаа бүр зогсоосон. Зөвхөн 2001 онд бид «Монголын нууц товчоон»-ы орчуулгаа гарган хэвлүүлсэн. Тус номын зураг чимэглэлийг миний анд найз зохиолч, зураач Ж.Саруулбуян зурсан. Цаашдаа Г.Б.Ярославцев бид хоёр Лувсанданзаны «Алтан товч», Рашпунцагийн «Болор эрх», «Оюун түлхүүр», Монголын түүхийн бусад сурвалж бичгүүдийг судалж хэсэгчлэн орчуулсан.

2004 онд миний хайртай багш Г.Б.Ярославцев насан өөд болсон юм. Бид хоёрын эхэлсэн ажлыг би цаашид ганцаараа үргэлжлүүлэн, 2009 онд «Чингисиана. Свод свидетельств современников» гэдэг номыг хэвлүүллээ. Уг номонд «Монголын нууц товчоо»-ноос гадна, Монголын түүхийн бусад сурвалж бичгүүдэд орсон Чингис хааны тухай домог, Чингис хааны Их засаг, билиг, Чингис хааны тухай, Их Монгол Улсын тухай гадаадынхны бичсэн тэмдэглэлийг оруулав.

2009- 2021 онуудад энэ номыг янз бүрийн хэвлэлийн газар, өөр өөр цуврал номд 4 удаа дахин хэвлэн гаргасан.

**- Таныг монголч эрдэмтэн, орчуулагч төдийгүй Чингис хаан, Тамерлан буюу Доголон Төмөр хааны тухай зэрэг хэд хэдэн номоо орос хэлээр бичсэнийг Монголын зарим түүхчид, түүх сонирхогчид, судлаачид сайн мэднэ. Орос хэлээр бичигдсэн учраас таны номын талаар зарим түүх сонирхогч хүмүүс уншиж чадаагүй, төдийлөн сайн мэдэхгүй байж магадгүй юм. Та эдгээр бүтээлийнхээ талаар ярьж өгнө үү.**

- 2016 онд «История российского государства» («Оросын төр улсын түүх») цуврал номонд гарсан «Ордынский период. Лица эпохи» гэдэг номонд Их Монгол улсын дөрвөн их хаад, Алтан Ордны улсын хаадын түүхэн хөргүүдийг Монголын түүхийн сурвалж, монгол, гадаадын судлаачдын ном зохиолуудыг үндэслэн бичиж хэвлүүлсэн юм. Мөн онд «Иллюстрированная военная история» («Цэрэг дайны зурагт түүх») цуврал номонд хэвлэгдэн гарсан «Чингисхан. Имперская идея завоевателя мира» гэдэг номондоо Чингис хааны үеийн монгол цэргийн зохион байгуулалт, дайн байлдааны арга тактикийн талаар монгол болон гадаадын түүхч, судлаачдын

Mongols. I had translated the entire text together with interpretations while G. B. Iaroslavtsev translated all poetry.

Even though translation work was completed in 1990, we could not manage to publish it. At that time, most Russian publications restricted their activities to only a few limited works and some of them even ceased their work due to economic difficulties.

Only in 2001, were we able to publish a Russian translation of the Secret History of the Mongols. My friend and writer J. Saruulbuyan drew all decorations and illustrations in this book.

Furthermore, G. B. Iaroslavtsev and I studied some other Mongolian historical texts such as 'Golden Chronicles' by Luvsandan, 'Crystal Rosary' by Rashpuntsag, 'Mind Key' (Oyun tulhuur), etc., and did some partial translations of them.

Unfortunately, my beloved mentor G. B. Iaroslavtsev passed away in 2004. Thereafter, I continued alone with those works we started together. In 2009, I published a work, titled, 'Chinggis: Collections of Modern Testimonies'. This work presents Chinggis Khaan's myths, Chinggis Khaan's Great Law (Ikh Zasag) and Chinggis Khaan's Wisdom, which were carefully selected from the Secret History of the Mongols and various other Mongolian historical texts. Also from notes and records by foreigners about Chinggis Khaan and his Great Mongol Empire. Between 2009 and 2021, this work has been published four times as other serials by various publications.

**- You are well-known among Mongolian historians and researchers not only as a scholar and translator in Mongolian studies but also you published several works on Chinggis Khaan and Tamerlane in Russian. However, there still might be many other Mongolian readers who do not know about your works since they are only published in Russian. Would you give our readers some information about those works?**

In 2016, the 'History of Russian Statehood' serials were published. I worked on historical portraits of four great emperors of the Great Mongol Empire and kings of the Golden Horde, which are contents of a series, titled, 'Horde Period: Face of the Period', based on Mongolian historical texts and research works by foreign scholars.

In the same year, I presented both Mongolian and foreign scholars' views and conclusions about Chinggis Khaan's Mongol army structure and war tactics to Russian readers in a work, titled, 'Chinggis Khaan: The World Conqueror's Imperial Idea' (Чингисхан. Имперская идея завоевателя мира), which constitutes a serial in 'An Illustrated History on Wars' Serials. This book was republished in 2018 as part of 'Bibliotheca of War and History Literatures' (Библиотека военной и исторической литературы) serials. I published my work titled, 'Tamerlane' in 2019 as a part of the above-mentioned serials based on stories and laws written by Tamerlane himself and also Middle as well as Central Asian and Russian historical texts from that particular period.



дэвшүүлсэн өөр өөрийн дүгнэлтийг Оросын уншигчдад танилцуулсан. 2018 онд энэ номыг «Библиотека военной и исторической литературы» («Цэрэг дайн, түүхийн зохиолын номын сан») цуврал номонд дахин хэвлэн гаргав. 2019 онд дээрх цуврал номонд «Тамерлан» гэдэг номоо гаргалаа. Тэр номыг Тамерланы өөрөө бичиж боловсруулсан цэдиг, их хууль болон тухайн үеийн Ойрхи Дорнод, Төв Ази, Оросын түүхийн сурвалж бичгүүдийг ашиглан бичжээ. онд «История российского государства» («Оросын төр улсын түүх») цуврал номонд гарсан «Ордынский период. Лица эпохи» гэдэг номонд Их Монгол улсын дөрвөн их хаад, Алтан Ордны улсын хаадын түүхэн хөргүүдийг Монголын түүхийн сурвалж, монгол, гадаадын судлаачдын ном зохиолуудыг үндэслэн бичиж хэвлүүлсэн юм. Мөн онд «Иллюстрированная военная история» («Цэрэг дайны зурагт түүх») цуврал номонд хэвлэгдэн гарсан «Чингисхан. Имперская идея завоевателя мира» гэдэг номондоо Чингис хааны үеийн монгол цэргийн зохион байгуулалт, дайн байлдааны арга тактикийн талаар монгол болон гадаадын түүхч, судлаачдын дэвшүүлсэн өөр өөрийн дүгнэлтийг Оросын уншигчдад танилцуулсан. 2018 онд энэ номыг «Библиотека военной и исторической литературы» («Цэрэг дайн, түүхийн зохиолын номын сан») цуврал номонд дахин хэвлэн гаргав. 2019 онд дээрх цуврал номонд «Тамерлан» гэдэг номоо гаргалаа. Тэр номыг Тамерланы өөрөө бичиж боловсруулсан цэдиг, их хууль болон тухайн үеийн Ойрхи Дорнод, Төв Ази, Оросын түүхийн сурвалж бичгүүдийг ашиглан бичжээ.

#### **- Сүүлийн үед та Монголын түүхийн талаар ямар бүтээл туурвиж байна?**

- Сүүлийн гурван жилд би хоёр ном, тухайлбал, «Чингис хаан. Ертөнцийг үзэх үзэл ба үйлдэл» гэдэг намтар зохиол болон «Чингис хааны Их засаг» зэрэг номыг бичиж дууссан. Эхний номд Чингис хааны ертөнцийг үзэх үзэл яаж төлөвшиж, түүний үндсэн дээр Чингис хаан тэнгэрлэм гэдэг үзэл суртлаа боловсруулан хэрэгжүүлж эхэлсний тухай өгүүлж буй. «Чингис хааны Их засаг» гэдэг номдоо Монголын болон гадаадын түүхийн сурвалж бичиг, ном зохиолуудыг ашиглан Чингис хааны 100 гаруй засаг, зарлигийг орос хэлэнд орчуулж дэлгэрэнгүй тайлбартай оруулсан.

Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой болох гэж байгаа энэ жилд дээрх хоёр номыг хэвлүүлэхээр шамдаж байгаа юм.

Ярилцсан: Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан, доктор Х.Мэндсайхан.

#### **- What are your most recent research works on Mongolian history?**

In the past three years, I have completed two books, titled, 'Chinggis Khaan: World-view and Action', biographical work and 'Chinggis Khaan's Great Law'.

In the first work, I presented how Chinggis Khaan's worldview was developed and then how he worked out his 'Tengerism' as propaganda and applied this in his activities.

Whereas I presented my Russian translations of over 100 law instructions by Chinggis Khaan together with their interpretations based on Mongolian and foreign historical texts and publications in the latter one.





Now I am planning to publish these works this year as my dedication to the 860th birthday anniversary of Chinggis Khaan.

Interview is by: Kh. Mendsaikhan, a researcher, Institute of Chinggis Khaan Heritage and Culture

Чингис хааны өв соёлын хүрээлэн

Чингис хааны  
ов соелын  
хууэлэм

ОРОСЫН МОНГОЛ СУДЛААЧ МЕЛЕХИН АЛЕКСАНДР ВИКТОРОВИЧИЙН БҮТЭЭЛҮҮДЭЭС




**ШИНЭ НОМЫН ТАНИЛЦУУЛГА**  
**NEW PUBLICATIONS**





ЧИНГИС ХААНЫ ӨВ, СОЁЛЫН ХҮРЭЭЛЭНГЭЭС ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛСЭН СУДАЛГААНЫ БҮТЭЭЛҮҮД



**ЧИНГИС ХААНЫ ӨВ, СОЁЛ  
АРХИВЫН БАРИМТЫН ЭМХЭТГЭЛ**

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Чингис хааны өв, соёлын хүрээлэн хамтран эл баримтын эмхэтгэлийг хэвлүүллээ. Үндэсний Төв Архивт хадгалагдаж байгаа эдгээр баримтууд нь хэдийгээр он цагийн хувьд Чингис хаанаас хойших үед хамаарах боловч агуулгын хувьд өргөн цар хүрээтэй, өнөөг хүртэл эргэлтэд ороогүй байгаа учраас шинжлэх ухаан, танин мэдэхүйн хувьд ач холбогдолтой бүтээл юм.


Эмхэтгэлд орсон баримтууд нь 1830-1962 оныг хамрах бөгөөд үүнд Монголчууд Манжийн эрхшээлд байх үе, Тусгаар тогтнолоо сэргээсэн Монгол улс /1911-1921/-ын үе, Ардын засаг болон түүнээс хойших үеийн /1921-1962/ баримтууд багтжээ.

**'CHINGGIS KHAAN'S HERITAGE AND CULTURE: A  
COMPILATION OF ARCHIVE DOCUMENTS'**

In cooperation with the Institute of History and Ethnography, Mongolian Academy of Sciences, the Institute had published a compilation of documents related to Chinggis Khaan's Heritage and Culture which are preserved in the Historical Document Archive of Mongolian National Central Archive.

Even though, these are much later period documents than Chinggis Khaan, their contents have a broad scope and have never been disseminated among research community circulations before. These documents are dated in between 1830-1962 and classified as (i) Manchu Qing period; (ii) Bogd Khaan's Mongolia /1911-1921/; and (iii) People's Government and thereafter /1921-1962/.

ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠠᠮ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠠᠨ



**ЧИНГИС ХААНЫ ӨВ, СОЁЛ БОТЬ I**

**CHINGGIS KHAAN HERITAGE AND CULTURE' PUBLICATION**

Монгол Улсын Үндэсний Номын сан, Үндэсний Төв Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй XVII-XIX зууны үед хамаарах “Алтан навчит нэрт алтан ургийн угсааны аймгийн ноёдын салбар”, “Чингис хааны домог оршвой”, “Суут богд Чингис хааны үлгэр бөлгөө”, “Богд Чингис хааны тахил үйлдэхийн ёс хэрэг хүслийг түргэн бүтээгч цэнгэл хэмээгдэх оршвой” зэрэг эх бичиг, сурвалжууд болон хааны сүлдний сан, тахилгуудыг түүхийн ухааны доктор Х.Мэндсайхан, Н.Саруул, судлаач Г.Тайванжаргал нар кирилл үсэгт хөрвүүлэн, галиг тайлбар хийж хэвлүүлээ.

The Institute has conducted research works on some source texts, dating back to between the 17th and 19th centuries, and published them as a compilation in modern Mongolian scripts along with transliterations and glossaries. This new publication presents valuable texts such as ‘Golden Leaves: Nobles of Golden Lineage Family’, ‘A Myth of Chinggis Khaan’, ‘A Tale of Genius Bogd Chinggis Khaan’, ‘Swift Benefit and Wish-fulfilling Joy Offering Rituals to the Supreme Bogd Chinggis Khaan’, ‘An Incense Burning Offering to Chinggis Khaan’s Sulde’, etc. These texts were transliterated and analysed by PhD. Kh. Mendsaikhan and N. Saruul, and a researcher G. Taivanjargal.

ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠭᠠᠨ ᠶᠡᠪ ᠰᠣᠶ᠋ᠯ ᠪᠣᠲᠦ II



### ЧИНГИС ХААНЫ ӨВ, СОЁЛ БОТЬ II

### 'CHINGGIS KHAAN HERITAGE AND CULTURE' SERIALS. VOLUME, NO II

Эл бүтээлд “Олноо өргөгдсөн хаанаас дараалан олон монголчууд хэрэглэгдэх түүх” хэмээх монгол сурвалжийг түүхийн ухааны доктор Х.Мэндсайхан, судлаач Ш.Мөнхбаатар нар кирилл үсэгт хөрвүүлж, галиг тайлбарыг үйлдэж, доктор Ц.Цэрэндорж хянан, судлаач Г.Цэнд-Аюуш техник редактор хийсэн болно. Эл түүхийн сурвалжид Энэтхэг, Төвөдийн хаадын үүсэл, угсаа залгамжлал, Чингис хаанаас өмнөх Монголын хаадын уг гарвал, угсаа залгамжлалыг өгүүлсэн нь ихээхэн сонирхолтой юм.

The Institute has published the second volume of our ‘Chinggis Khaan Heritage and Culture’ Serials. This volume presents a valuable Mongolian historical manuscript titled, “Chronology of Mahasamatha /Sublimed by All or Great Choice/ Kings as a historical manual for Mongols”. Transliteration work from classical Mongolian into modern Mongolian is by PhD. Kh. Mendsaikhan and Sh. Munkhbaatar together with clear explanations and phonetics of those ancient terms. The work is edited by PhD. Ts. Tserendorj and sub-edited by G. Tsend-Ayush.

This manuscript is quite significant for it presents the origins and successions of Indian and Tibetan kings, and the origins and successions of Mongolian kings before Chinggis Khaan.





ЧИНГИС ХААНЫ  
ӨВ СОЁЛЫН  
ХҮРЭЭГЭМ

### ЧИНГИС ХААНЫ ӨВ, СОЁЛ БОТЬ III

Тус бүтээлд Цэвэгжавын “Чингис хааны хураангуй шастир” хэмээх монгол бичиг, хятад хэлээрх хадмал орчуулга бүхий хорголжин барын тигээр хэвлэсэн бэсрэг сурвалжийг доктор Х.Мэндсайхан кирилл үсэгт хөрвүүлж, судлаач Б.Мягмаржав хятад ханзыг дагалдуулж, галиг тайлбар үйлдэн, доктор О.Оюунжаргал хянан тохиолдуулсан болно. Эл түүхийн эх сурвалжид Чингис хааны аравдугаар үеийн өвөг Бодончараас эхлэн Чингис хаан хүртэлх үе залгамжлал, Хайдугийн хаан болсон үйл явдал болон тухайн үеийн овог, аймгийн байр байдлыг өгүүлснээс гадна, Чингис хааны намтрыг товчлон бичжээ.

### ‘CHINGGIS KHAAN HERITAGE AND CULTURE’ SERIALS. VOLUME, NO III

The Institute has published the third volume of our ‘Chinggis Khaan Heritage and Culture’ Serials. This volume presents a lead block print “A Concise Treatise of Chinggis Khaan”, which is written in classical Mongolian and provided with word to word Chinese translation, by Tsevegjav. This source text is transliterated in modern Mongolian by PhD. Kh. Mendsaikhan and Chinese characters are chosen by B. Myagmarjav, a research worker, and edited by PhD. O. Oyunjargal.

This historical source text presents a golden lineage from Bodonchar, who is the 10th ancestor of Chinggis Khaan, up to Chinggis Khaan, how Khaidu enthroned as an emperor and how the political positions of various Mongol clans and aimags were. Furthermore, it gives a concise account of Chinggis Khaan’s biography.



**МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН СУДЛАЛЫН  
ЧУУЛГАН БОТЬ II**

Монголын нууц товчоон зохиогдож дууссаны 780 жилийн ойд зориулан хэвлүүлсэн “Монголын нууц товчоон судлалын чуулган” хэмээх судалгааны бүтээлийн II ботид Хэл бичгийн ухааны доктор Э.Пүрэвжавын олон жилийн туршид бичиж нийтлүүлж байсан 21 шилдэг өгүүлийг шинэчлэн нэгтгэж, эмхэтгэн орууллаа.

**‘ASSEMBLY OF THE SECRET HISTORY OF  
THE MONGOLS STUDIES’, II VOLUME BY PH.D.  
PUREVJAV ERDENE**

This is a compilation of twenty-one of the best scientific articles, dedicated to the 780th anniversary of the Secret History of the Mongols, by a linguist E.Purevjav.

ᠴᠢᠩᠭᠢᠰᠢᠶᠢᠨ ᠴᠢᠯᠠᠭᠤᠨ ᠪᠢᠴᠢᠭᠢᠨ ᠰᠤᠳᠠᠯᠭᠠᠭ



**ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧГИЙН СУДАЛГАА  
200 ЖИЛИЙН ТҮҮХ: СУДЛААЧ, БҮТЭЭЛ,  
ТАЙЛБАР**

Доктор Б.Түвшинтөгсийн эмхэтгэсэн “Чингисийн чулууны бичгийн судалгаа 200 жилийн түүх: судлаач, бүтээл, тайлбар” номыг Чингис хааны өв, соёлын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлэв.

Энэхүү номд Чингисийн чулууны бичиг буюу Чингис хааны ач дүү Есүнгэ ноёны хөшөөний бичиг, Хархираагийн хөшөөний бичиг гэх зэргээр тэмдэглэсэн монгол бичгийн одоогоор мэдэгдэж буй хамгийн эртний дурсгалыг нээж олсон түүх, судалж ирсэн байдал, уншиж тайлбарласан талаарх тойм болон уг дурсгалыг 200 жилийн туршид судалсан зарим бүтээлийг эмхэтгэн олон түмний хүртээл болгож байна.

**‘TWO HUNDRED YEARS OF STUDIES ON THE  
STELE OF CHINGGIS KHAAN: RESEARCHERS,  
WORKS AND INTERPRETATIONS’, A  
COMPILATION PUBLICATION**

The Institute had published a compilation titled, ‘Two Hundred Years of Studies on the Stele of Chinggis Khaan: Researchers, Works and interpretations’ by PhD. B. Enkhtuvshin.

This presents an outline of the Stele of Chinggis Khaan or more precisely, Stelle of Chinggis Khaan’s nephew Yisüngge, which is the most ancient memorial of Classical Mongolian scripts at this time; how it was first discovered in Kharkhiraa in Transbaikal and 200 years of research following of this discovery. This publication is a compilation of some selected research works on this subject.



چنگیز خانین Өв Соёлын Хүрээлэн



**ДАНИ ДАХЬ МОНГОЛЫН ӨВ СОЁЛЫН  
ДУРСГАЛУУД**

Чингис хааны өв, соёлын хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбоо, Дани улсын Копенхагены хааны музей хамтран “Дани дахь Монголын өв соёлын дурсгалууд” бүтээлийг хэвлүүлсэн юм.

**“MONGOLIAN CULTURAL HERITAGE  
ITEMS IN DENMARK”**

‘Mongolian Cultural Heritage Items in Denmark’, a catalogue, is published in cooperation with the Institute of Chinggis Khaan Heritage and Culture, International Association of Mongolian Studies and Amalienborg palace in Copenhagen of Denmark.

ᠡᠷᠮᠢᠲᠠᠵᠢ ᠳᠠᠬᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ ᠶᠡᠭᠡᠨ ᠭᠦᠢᠨ ᠳᠤᠷᠰᠠᠭᠠᠯᠤᠳᠤ



**ЭРМИТАЖ ДАХЬ МОНГОЛЫН ЭЗЭНТ  
ГҮРНИЙ ҮЕИЙН ДУРСГАЛУУД**

Чингис хааны өв, соёлын хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбоо, “Чингис хаан” музей, ОХУ-ын Эрмитаж музей хамтран “Эрмитаж дахь Монголын Эзэнт гүрний үеийн дурсгалууд” бүтээлийг хэвлүүлсэн юм.

**“HERMITAGE MUSEUM CULTURAL ITEMS  
RELATED TO THE GREAT MONGOL  
EMPIRE”**

“Hermitage Museum Cultural Items Related to the Great Mongol Empire” Catalogue is published in cooperation with the Institute of Chinggis Khaan Heritage and Culture, the International Association of Mongolian Studies, Chinggis Khaan Museum, and State Hermitage Museum of Russia.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯᠴᠢᠳᠤ



**МОНГОЛ ОРОН МОНГОЛЧУУД**

Чингис хааны өв, соёлын хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбоо, Английн Хааны газарзүйн нийгэмлэг хамтран эрхэлсэн энэхүү бүтээлд Манж Чин гүрний сүүл үеийн болон Монголын эрх чөлөөний эхний жилүүдийг гэрэл зурагт тусган харуулахдаа Өргөө дэх Үндэсний их баяр наадам, ард түмэн, Нийслэл дэх өдөр тутмын амьдрал, харгис хэрцгий шорон, томоохон сүм хийдүүд, өөрчлөгдөж буй газар нутаг сэдвийг хамруулжээ.

**MONGOLIA AND MONGOLS, VOLUME NO, VIII.**

The Eighth volume of “Mongolia and Mongols” is published in cooperation with the Institute of Chinggis Khaan Heritage and Culture, the International Association of Mongolian Studies and the Royal Geographical Society. This publication shows you how the National Naadam games in Urga, the old Mongolian capital were, the general appearance of people, daily life of the Mongolian capital, ruthless prisons, large Buddhist monasteries and changing landscapes, etc., during the final period of Qing rule and first years of Mongolian independence.



ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ




**“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН СУДЛАЛ”  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ**

Чингис хааны өв, соёлын хүрээлэнгээс зохион байгуулсан “Монголын нууц товчоон судлал” Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл хэлэлцүүлсэн гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын нийт 39 илтгэлийг эмхэтгэн хэвлүүлсэн.

**“THE SECRET HISTORY OF THE MONGOLS  
STUDIES”, A COMPILATION OF INTERNATIONAL  
SCIENTIFIC CONFERENCE REPORTS**

This publication is a compilation of thirty-nine scholars’ reports which were presented for the scientific conference ‘the Secret History of the Mongols’ Studies, organised by the Institute.

چنگیز خانین  
او سوئلین  
خوولون



**ЧИНГИС ХААНЫ УГСААНЫ ЗАСАГ НОЁДЫН  
ТАМГА**

Түүхийн ухааны доктор На.Батболдын эмхэтгэсэн “Чингис хааны угсааны засаг ноёдын тамга” бүтээлд Манж Чин гүрний үеийн 60 шахам хошуудын тамганы зураг, дардасыг оруулжээ.

**“SEALS OF CHINGGISID GOVERNORS”  
PUBLICATION.**

“Seals of Chinggisid Governors”, compiled by PhD. Na. Batbold, presents photos of those governors’ seals together with translations of Manchu inscriptions on them.

Сүлдэр  
Бурхан Халдун  
Ж. Саруулбуян



**БУРХАН ХАЛДУНЫ СҮЛДЭР**

Доктор Ж.Саруулбуян зохиож, доктор З.Лонжид, Х.Мэндсайхан нарын хянан тохиолдуулсан “Бурхан Халдуны Сүлдэр” номд Бурхан Халдун хайрхан, Чингис хааны тухай сэдвийг дагнан хөндсөн өгүүлэл, тэмдэглэл, эрэгцүүлэл, ярилцлага болон бусад бичвэрийг багтаан оруулсан байна.

**“SPIRIT OF THE BURKHAN KHALDUN MOUNTAIN” PUBLICATION**

“Spirit (Sulde) of the Burkhan Khaldun Mountain” by J. Saruulbuyan, and edited by Z. Lonjid and Kh. Mendsaikhan, deals with various thought-provoking articles, notes, speculations and interviews about Burkhan Khaldun Mountain and Chinggis Khaan.



ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ ᠶ᠋ᠢᠰᠤᠨ ᠰᠣᠶ᠋ᠣᠯᠢ ᠶ᠋ᠢᠵᠢᠨ ᠠᠶᠢᠯᠠᠯ ᠵᠤᠸᠠᠯᠠᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠬᠥᠭᠵᠢᠯᠢᠨ ᠪᠣᠯᠣᠮᠵᠢ



**“МОНГОЛЫН ТҮҮХ, СОЁЛЫН АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛ: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН  
БОЛОМЖ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН  
ЭМХЭТГЭЛ**

“Монголын түүх, соёлын аялал жуулчлал: өнөөгийн байдал, хөгжлийн боломж” бол түүх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц боломж, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөгжлийн чиг хандлагын талаар хэлэлцүүлсэн эрдэм нийт 23 эрдэмтэний илтгэлийн эмхэтгэл юм.

**“MONGOLIAN HISTORY AND CULTURAL  
TOURISM: CURRENT SITUATIONS AND  
DEVELOPMENT OPPORTUNITIES”, A  
COMPILATION OF CONFERENCE REPORTS.**

“Mongolian History and Cultural Tourism: Current Situations and Development Opportunities” is a compilation of 23 scientific reports on possibilities of developing historical and cultural tourism, generating more tourism products and future tendencies.



ЧИНГИС ХААНЫ  
ЦЭРЭГ, ДАЙТАХ  
УХААН, ЗЭР  
ЗЭВСЭГ

**ЧИНГИС ХААНЫ ЦЭРЭГ, ДАЙТАХ УХААН, ЗЭР  
ЗЭВСЭГ**

Түүхч, доктор, профессор Ж.Базарсүрэнгийн “Чингис хааны цэрэг, дайтах ухаан, зэр зэвсэг” номонд Хамаг Монгол улс, Их Монгол улсын цэргийн байгуулалт, цэргийн эрдэм ухаан буюу цэргийн урлаг, зэр зэвсгийн тухай өгүүлнэ.

**‘CHINGGIS KHAAN’S ARMY, WAR STRATEGIES  
AND WEAPONS’**

by PhD, Prof. J. Bazarsuren presents a detailed and comprehensive accounts of the Mongolian army structure, war strategies and tactics, and weapons during the Khamag Mongol and Mongol Empire periods.

